

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр
тасалбар болсон жилийн

ТУСДАА САНХҮҮГИЙН ТАЙЛАН

/ НББОУС 27-ын дагуу илэрхийлэгдсэн/

“ИНВЕСКОР ББСБ”
Хувьцаат Компани



“ИНВЕСКОР ББСБ” ХК

Байгууллагын талаарх мэдээлэл

Үүсгэн байгуулах шийдвэр	“Инвескор ББСБ” Хувьцаат Компани (Цаашид “Компани” гэх) нь 2016 оны 04-р сарын 21-ний өдрийн үүсгэн байгуулагчийн шийдвэрээр Монгол улсын хууль тогтоомжийн дагуу Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр анх үүсгэн байгуулагдсан.		
Гэрчилгээ	2016 оны 03-р сарын 29-ний өдөр Монгол улсын Улсын Бүртгэлийн Албанд бүртгүүлж 6060854 тоот регистр бүхий 9015003118 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээг авсан. 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдөр компанийн үйл ажиллагаанд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг тусган 9010002004 тоот бүхий Улсын Бүртгэлийн Гэрчилгээг дахин шинээр авсан. 2019 оны 07-р сарын 16-ны өдөр Орхон аймаг, Баян-Өндөр сум, 3-р баг, Уурхайчин, 3-р хороолол, 22, 74 тоотод байрлах салбар нэгжийг шинээр бүртгүүлсэн.		
Тусгай зөвшөөрөл	Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 159 дугаар тогтоолоор Банк Бус Санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн 1/554 тоот гэрчилгээ авсан.		
Үндсэн үйл ажиллагаа	“Инвескор ББСБ” ХК-ийн үндсэн үйл ажиллагаа нь Зээлийн үйл ажиллагаа, Факторингийн үйлчилгээ, Итгэлцлийн үйлчилгээ, Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, Төлбөрийн баталгаа гаргах зэрэг болно.		
Хувьцаа эзэмшигчид		Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
	“Эс Ай Би Жэй Капитал” ХХК	60,968,730	85%
	Бусад	10,759,188	15%
Нэгтгэгдсэн	“Инвескор Эй Ай Лаб” ХХК (Монгол улсын хуулийн этгээд)- 90%-ийг бүрэн эзэмшдэг		
охин компаниуд	“Инвескор Хэтэвч ББСБ” ХХК (Монгол улсын хуулийн этгээд)- 100%-ийг бүрэн эзэмшдэг “Инвескор Жапан” ХХК (Япон улсын хуулийн этгээд)- 99.84%-ийг бүрэн эзэмшдэг		
Гүйцэтгэх Удирдлага	Гүйцэтгэх захирал	Д.Баясгалан	
	Дэд захирал	Р.Мөнхтөр	
	Санхүү хариуцсан дэд захирал	Р.Пүрэв	
Төлөөлөн удирдах зөвлөл	ТУЗ-ийн дарга	Б.Анхболд	
	ТУЗ-ийн гишүүн	Д.Баясгалан	
	ТУЗ-ийн гишүүн	Р.Мөнхтөр	
	ТУЗ-ийн гишүүн	Г.Уянгахишиг	
	ТУЗ-ийн гишүүн	Т.Тэлмэн	
	ТУЗ-ийн гишүүн	Namiki Hirohito	
	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Ч.Хашчулуун	
	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Д.Энхбат	
	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Ч.Өнөржаргал	
Байнгын хаяг	“Инвескор ББСБ” ХХК Твин Тауэр-1 байр, 13 давхар Сөүлийн гудамж Сүхбаатар		
Аудитор	“БДО Аудит” ХХК Юнион Бюлдинг В блок, 15-р давхар, 1502 тоот, Юнескогийн гудамж, Нарны зам-62, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Улаанбаатар хот, Монгол Улс		

**2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
тусдаа санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх
Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл**

Энэхүү тайлангийн 3-6 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь “Инвескор ББСБ” Хувьцаат Компанийн (цаашид ‘Компани’ гэх) 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн тусдаа санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

Компанийн удирдлага нь эдгээр тусдаа санхүүгийн Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 27, *Тусдаа Санхүүгийн Тайлан* (“НББОУС 27”)-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно. Бид эдгээр тусдаа санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 27, *Тусдаа Санхүүгийн Тайлан*, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

Компанийн 2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн тусдаа санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.



Д.БАЯСГАЛАН
Гүйцэтгэх захирал
УЛААНБААТАР ХОТ

Р.ПҮРЭВ
Санхүү хариуцсан дэд захирал

Огноо: 2020.03.28

Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ИНВЕСКОР ББСБ” ХК -ийн Хувьцаа эзэмшигчдэд

Тусдаа санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

Санал дүгнэлт

“Инвескор ББСБ” ХК (‘Компани’ гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн тусдаа санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2019 оны 12-р сарын 31-нээрх тусдаа санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөр тасалбар болсон жилийн тусдаа ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлан, тусдаа мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан тусдаа санхүүгийн тайлангууд нь компанийн 2019 оны 12-р сарын 31-ний өдрийн тусдаа санхүүгийн байдал, тусдаа санхүүгийн гүйцэтгэл болон тусдаа мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, *Тусдаа санхүүгийн тайлан* (“НББОУС 27”) -ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (‘АОУС’)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлага энэ тайлангийнхаа тусдаа санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (‘НБЭЗОУСЗ’)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус байсан бөгөөд НБЭЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

Асуудлыг онцлох нь

Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл 38, тайлангийн өдрийн дараах үйл явдалд анхаарлаа хандуулна уу. 2020 оны 1 сараас Дэлхий нийтээр тархсан COVID 19 буюу коронавирусын тархалтын нөлөөллөөс хамааран “Инвескор ББСБ” ХК-ийн харилцагчдын зээл болон хүүгийн эргэн төлбөр нь хугацаандаа хийгдэхгүй байх эрсдэлийн талаар дурдсан. Бид энэхүү асуудлаар дүгнэлтээ өөрчлөөгүй болно.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Аудитын гол асуудал

Аудитын хариу

1

Харилцагчдад олгосон зээлийн үнэ цэнийн бууралт

Компанийн нийт хөрөнгийн 75.7% (2018: 89.35%) - ийг харилцагчдад олгосон зээл эзэлж байна. Зээлийн үнэ цэнийн бууралтыг тодорхойлохдоо өнгөрсөн хугацаанд тохиолдсон алдагдлын түүхэн мэдээлэл дээр үндэслэн зээлийн бүтээгдэхүүн тус бүр дэх макро эдийн засгийн хүчин зүйлсийн нөлөөллийг авч үзэн магадлалаар таамагласан ирээдүйн мөнгөн урсгалын талаарх удирдлагын төсөөлөлд үндэслэн тооцоолдог. Тайлант жилийн эцэс дэх зээлийн үнэ цэнийн бууралтын гарзыг удирдлагаас тусгайлсан болон бүлгийн үнэлгээний загвар ашиглан тодорхойлсон. Ингэхдээ СТОУС 9-н дагуу зээл болон түүнтэй адилтгах хөрөнгийг 3 шатлалд хуваан авч үзэн хүлээгдэж буй алдагдлын загвараар үнэ цэнийн бууралтын тооцоолол хийсэн. Дэлхий нийтээр тархаад буй "COVID 19" вирустай холбоотойгоор макро эдийн засгийн үзүүлэлт таамаглаж байсан түвшинд хүрэхгүй талаар эдийн засаг судлаачид үзэж тул энэхүү нөлөөллийг харгалзан үзэж зээлийн үнэ цэнийн бууралтын тооцоолол дах макро эдийн засгийн таамагласан үзүүлэлтийг бууруулж тооцсон.

Ашигласан таамаглалууд зохисгүй байж болзошгүй учраас бид энэхүү удирдлагын тооцооллыг аудитын гол асуудалд оруулсан.

Хавсаргасан тусдаа санхүүгийн тайлангийн Тэмдэглэл 20-оос үзнэ үү.

Зээлийн үнэ цэнийн тооцооллыг үнэлэхдээ бид дараах горимууд гүйцэтгэсэн:

- Компанийн зээлийн үнэ цэнийн бууралт, хүлээн зөвшөөрөлт, хяналтуудыг бид үнэлсэн;
- Үнэ цэнийн бууралтын тооцоолол нь СТОУС 9-өөр шаардсан арга, аргачлалын дагуу хийгдсэн эсэх нийцлийг шалгасан;
- Компанийн зээлийн үнэ цэнийн бууралтын тооцоололд ашигласан зээлийн өгөгдлийн иж бүрэн байдал, ашигласан орц мэдээллийн найдвартай байдлыг шалгасан;
- Зээлийн бүлгийн ангилалд багтсан зээлийг холбогдох зөв ангилалд хамруулж, насжилтыг зөв гаргасан эсэхийг шалгаж зохих журмын дагуу дахин ангилсан;
- Зээлийн үнэ цэнийн бууралтыг тодорхойлоход удирдлагын зүгээс ашигласан магадлалуудыг бид компанийн зээлийн мэдээлэлтэй тулгасан;
- Хүлээгдэж буй зээлийн алдагдалтай холбоотой нэмэлт тодруулгууд нь хангалттай эсэхийг үнэлсэн.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй.

Тусдаа санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Тусдаа санхүүгийн тайлангийн аудиттайгаа холбогдуулан бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, ингэснээр бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитаар олж авсан бидний мэдлэг эсвэл өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай материаллаг үл нийцлийг авч үзэхэд оршдог. Бид өөрсдийн гүйцэтгэсэн ажил дээрээ суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл тухайн бодит байдлыг тайлагнахыг биднээс шаарддаг. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Тусдаа санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Тусдаа санхүүгийн тайлангуудыг НББОУС 27, *Тусдаа санхүүгийн тайлан* (“НББОУС 27”)-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, болон алдаа юм уу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Тусдаа санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь компанийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх компанийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Тусдаа санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс тусдаа санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлж байна гэж амласан баталгаа гаргадаггүй.

Алдаа зөрчил нь заль мэхнээс эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд хэрэв тэр нь дангаараа эсвэл нийлэхээрээ тусдаа санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Заль мэх эсвэл алдааны улмаас тусдаа санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Тусдаа санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)

- Мөн олж авсан аудитын нотолгоонд үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад тусдаа санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба тусдаа санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.
- Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан

Бид “Инвескор ББСБ” ХК -ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тусдаа санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон санхүүгийн жилийн тусдаа дэлгэрэнгүй орлогын тайлан, тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлан, тусдаа мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж дүгнэлтээ гаргасан.

Бид тусдаа санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцдаа санхүүгийн тайлагналтай холбоотойгоор компанид мөрдүүлэхээр зохицуулагч байгууллагаас гаргасан дүрэм, журмын даган мөрдөлтийн талаар тест гүйцэтгэсэн бөгөөд Монгол Улсын хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм, журмыг ноцтойгоор зөрчсөн гэсэн үл үндэслэлтэй нотолгоо бидэнд мэдэгдээгүй.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 95.1-р зүйлд заасан хуулийн этгээд болох “Инвескор ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.


Л. БАЯРЦОГЗОЛ
“БДО Аудит” ХХК
Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Юнескогийн гудамж, Нарны зам-62
Юнион Бюлдинг В блок, 1502 тоот өрөө



Огноо: 2020.03.28

“Инвекор ББСБ” ХК

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

	Тэм	2019 он мян.төг	2018 он мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	6	19,359,766	10,793,828
Хүү болон түүнтэй адилтгах зардал	7	(4,072,393)	(2,572,561)
Түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал	8	(120,367)	-
Хүүгийн цэвэр орлого		15,167,006	8,221,267
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	9	666,504	324,140
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого/(зардал)	10	159,123	77,927
Хүүгийн бус цэвэр орлого		825,627	402,067
Үйл ажиллагааны орлого		15,992,633	8,623,334
Боловсон хүчинтэй холбоотой зардал	11	(2,022,639)	(902,020)
Ерөнхий ба удирдлагын (зардал)	12	(1,466,452)	(491,784)
Үйл ажиллагааны бус бусад орлого/(зардал)	13	(116,237)	(80,320)
Бусад олз/(гарз)	14	(279,702)	(91,502)
Зээлийн үнэ цэнийн бууралтын өмнөх ашиг		12,107,603	7,057,708
Зээлийн үнэ цэнийн бууралтын (зардал), буцаалт	15	(56,963)	(880,264)
Зээлийн үнэ цэнийн бууралтын дараах ашиг		12,050,640	6,177,444
Орлогын албан татвар	16	(2,542,578)	(1,120,475)
Тайлант жилийн ашиг		9,508,062	5,056,969

12-69 дүгээр хуудсан дахь тэмдэглэлүүд нь тусдаа эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“Инвекор ББСБ” ХК

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөрх
Тусдаа Санхүүгийн байдлын тайлан

	Тэм	2019 оны 12 сарын 31 мян.төг	2018 оны 12 сарын 31 мян.төг
Хөрөнгө			
Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	17	4,440,168	2,297,690
Харилцагчдад олгосон зээл-цэвэр	20	62,301,229	34,868,286
Бусад санхүүгийн хөрөнгө	18	2,227,609	681,332
Бусад санхүүгийн бус хөрөнгө	19	1,334,864	132,018
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	21	1,055,576	417,534
Өмч, барилга, тоног төхөөрөмж-цэвэр	22	4,942,837	500,063
Ашиглах эрхтэй хөрөнгө	23	1,494,136	-
Биет бус хөрөнгө-цэвэр	24	536,619	118,170
Хөрөнгө оруулалт-өртгөөр	25	3,989,710	90
Нийт хөрөнгө		82,322,748	39,015,183
Өр төлбөр ба өмч			
Өр төлбөр			
Итгэлцлийн үйлчилгээний өр төлбөр	26	19,933,800	10,374,109
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	27	14,515,976	13,867,446
Бусад санхүүгийн өр төлбөр	28	4,186,441	496,390
Бусад санхүүгийн бус өр төлбөр	29	709,656	77,504
Болзошгүй өр төлбөр	30	774,302	-
Орлогын албан татварын өглөг	31	980,078	305,374
Нийт өр төлбөр		41,100,253	25,120,823
Өмч			
Хувьцаат капитал	32	16,282,237	6,096,873
Нэмж төлөгдсөн капитал	33	15,377,738	-
Хуримтлагдсан ашиг		9,562,520	7,797,487
Нийт өмч		41,222,495	13,894,360
Нийт өр төлбөр ба өмч		82,322,748	39,015,183

12-69 дүгээр хуудсан дахь тэмдэглэлүүд нь тусдаа эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“Инвекор ББСБ” ХК

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа Өмчийн өөрчлөлтийн тайлан

	Хувьцаат капитал		Нэмж төлөгдсөн капитал		Хуримтлагдсан ашиг		Нийт	
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	6,096,873	-	-	-	7,797,487	13,894,360		
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	9,508,062	9,508,062		
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг/(алдагдал)					9,508,062	9,508,062		
Гаргасан хувьцаат капитал	2,442,335		15,377,738			17,820,073		
Нэрлэсэн үнийн өсөлт	7,743,029		-		(7,743,029)	-		
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	16,282,237		15,377,738		9,562,520	41,222,495		
2018 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	6,096,873		-		2,740,518	8,837,391		
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	5,056,969	5,056,969		
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг/(алдагдал)					5,056,969	5,056,969		
2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	6,096,873		-		7,797,487	13,894,360		

“Инвескор ББСБ” ХК

**2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа Мөнгөн гүйлгээний тайлан**

	Тэм	2019 он мян.төг	2018 он мян.төг
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Тайлант жилийн татварын өмнөх ашиг/(алдагдал)		12,050,640	6,177,444
Тохируулга:			
Өмч, Барилга, Тоног төхөөрөмжийн элэгдэл	22	83,961	33,157
Биет бус хөрөнгийн хорогдуулга	24	23,725	8,126
Гадаад валютын хэрэгжээгүй ханшийн зөрүүний (олз)/гарз	10	(201,706)	-
Өмч, барилга, тоног төхөөрөмж борлуулалтын (олз)/гарз		-	84
Өмч, барилга, тоног төхөөрөмж данснаас хассаны (олз)/гарз		-	4,008
Зээлийн үнэ цэнийн бууралт	14	56,963	880,264
ӨБҮХХ үнэ цэнийн бууралт	15	279,702	21,976
Хүүгийн зардал	7	4,072,393	2,572,561
Түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал	8	120,367	-
Хүүгийн орлого	6	(19,359,766)	(10,793,828)
Ажлын капиталын өөрчлөлтөөс өмнөх үйл ажиллагааны ашиг		(2,873,721)	(1,096,208)
Ажлын капиталын өөрчлөлт:			
Харилцагчдад олгосон зээлийн (өсөлт)/бууралт		(27,810,687)	(18,089,274)
Худалдааны болон бусад авлагын (өсөлт)/бууралт		(106,850)	-
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн (өсөлт)/бууралт		225,659	100,384
Бусад санхүүгийн хөрөнгийн (өсөлт)/бууралт		489,970	-
Бусад санхүүгийн бус хөрөнгийн (өсөлт)/бууралт		(1,202,846)	-
Бусад санхүүгийн өр төлбөрийн (өсөлт)/бууралт		3,354,395	325,339
Бусад санхүүгийн бус өр төлбөрийн (өсөлт)/бууралт		(658,556)	(342,926)
Үндсэн үйл ажиллагаанаас бий болсон мөнгөн үрсгал		(28,582,636)	(19,102,685)
Төлсөн орлогын татвар		(1,867,874)	(761,000)
Хүлээн авсан хүү		13,273,199	10,247,900
Төлсөн хүү		(1,220,971)	(485,803)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(18,398,282)	(10,101,588)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Хараат болон хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалт	25	(3,989,620)	(90)
Өмч, барилга, тоног төхөөрөмжийн худалдан авалт	22	(1,056,820)	(255,941)
Өмч, барилга, тоног төхөөрөмжийн борлуулалт	22	698,934	2,073
Биет бус хөрөнгийн худалдан авалт	24	(442,174)	(309,713)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(4,789,680)	(563,671)
Санхүүжилтийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Хувьцаа гаргаснаас хүлээн авсан	32,33	17,820,073	-
Авсан зээл	27	2,641,586	19,053,583
Зээлийн эргэн төлөлт	27	(3,740,000)	(14,601,970)
Харилцагчдаас татсан итгэлцэл	26	17,660,744	11,969,883
Харилцагчдад төлсөн итгэлцэл	26	(9,135,930)	(4,946,383)
Гадаад валютын ханшийн зөрүү		-	383,654
Санхүүжилтийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		25,246,473	11,858,767
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт)/өсөлт		2,058,511	1,193,508
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18	2,297,690	1,104,182
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	10	83,967	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18	4,440,168	2,297,690

12-69 дүгээр хуудсан дахь тэмдэглэлүүд нь тусдаа эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“Инвескор ББСБ” ХК

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл

1. Тайлагнагч аж ахуйн нэгж	12	Зээлийн бүтээгдэхүүний ангиллаар:.....	36
2. Тайлан бэлтгэсэн үндэслэл.....	13	21. Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө.....	37
3. Шинээр батлагдсан, нэмэлт өөрчлөлт оруулсан стандарт болон тайлбарууд	13	22. Өмч, барилга, тоног төхөөрөмж-цэвэр	38
4. Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл.....	15	23. Ашиглах эрхтэй хөрөнгө.....	39
5. Санхүүгийн хэрэглүүр – Эрсдэлийн удирдлага	16	23. Ашиглах эрхтэй хөрөнгө (үргэлжлэл)	40
6. Хүү болон түүнтэй адилтгах орлого ..	28	24. Биет бус хөрөнгө-цэвэр.....	40
7. Хүү болон түүнтэй адилтгах зардал ..	29	25. Хөрөнгө оруулалт	41
8. Түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал	29	26. Итгэлцлийн үйлчилгээний өр төлбөр	42
9. Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	29	27. Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл	42
10. Ханшийн тэгшитгэлийн орлого/(зардал).....	29	27. Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл (үргэлжлэл)	43
11. Боловсон хүчинтэй холбоотой зардал	30	28. Бусад санхүүгийн өр төлбөр	44
12. Ерөнхий ба удирдлагын (зардал)	30	29. Бусад санхүүгийн бус өр төлбөр.....	44
13. Үйл ажиллагааны бус бусад орлого/ (зардал).....	31	30. Болзошгүй өр төлбөр	44
14. Бусад олз/(гарз).....	31	30. Болзошгүй өр төлбөр (үргэлжлэл)	45
15. Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал	31	31. Орлогын албан татварын өглөг	45
16. Орлогын албан татвар	32	32. Хувьцаат капитал	45
17. Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	32	33. Нэмж төлөгдсөн капитал	46
18. Бусад санхүүгийн хөрөнгө	33	34. Холбоотой талуудын ажил гүйлгээ ...	46
19. Бусад санхүүгийн бус хөрөнгө.....	33	35. Мөнгөн гүйлгээний тайланг дэмжих тэмдэглэл	49
20. Харилцагчдад олгосон зээл-цэвэр....	34	35. Мөнгөн гүйлгээний тайланг дэмжих тэмдэглэл (үргэлжлэл)	50
20. Харилцагчдад олгосон зээл-цэвэр (үргэлжлэл)	35	36. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө	51
20. Харилцагчдад олгосон зээл-цэвэр (үргэлжлэл)	36	37. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй	54
		38. Тайлант хугацааны дараах үйл явдал	69
		39. Тайлангийн орчуулга.....	69

“Инвескор ББСБ” ХК

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

1. Тайлагнагч аж ахуйн нэгж

“Инвескор ББСБ” ХК (Цаашид “Компани” гэх) нь 2016 оны 04-р сарын 21-ний өдрийн үүсгэн байгуулагчийн шийдвэрээр Монгол улсын хууль тогтоомжийн дагуу Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр анх үүсгэн байгуулагдсан. 2016 оны 03-р сарын 29-ний өдөр Монгол улсын Улсын Бүртгэлийн Албанд бүртгүүлж 6060854 тоот регистр бүхий 9010002004 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээг авсан. Тайлант жилд Хувьцаат компани хэлбэрээр дахин зохион байгуулагдсан бөгөөд 2019 оны 06-р сарын 11-ний өдөр өөрчлөлтийг Улсын Бүртгэлийн Албанд бүртгүүлж дахин шинэ гэрчилгээ авсан.

“Компани”-ийн үндсэн үйл ажиллагаа нь Зээлийн үйл ажиллагаа, Факторингийн үйлчилгээ, Итгэлцлийн үйлчилгээ, Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, Төлбөрийн баталгаа гаргах зэрэг болно.

Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 159 дугаар тогтоолоор Банк Бус Санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн 1/554 тоот гэрчилгээ авсан.

2019 оны 12-р сарын 31-ний байдлаар компанийн хувьцаа эзэмшигчид нь дараах байдалтай байна:

Хувьцаа эзэмшигчдийн нэр	Эзэмшлийн хувь	2019 оны 12 сарын 31		
		Тоо хэмжээ	Нэгжийн үнэ (төг)	Нийт (мян.төг)
“Эс Ай Би Жэй Капитал” ХХК	85%	60,968,730	227	13,839,901
Бусад*	15%	10,759,188	227	2,442,336
	100%	71,727,918		16,282,237

“Компани”-ийн хамгийн дээд хянагч болон толгой компани нь “Эс Ай Би Жэй Капитал” ХХК болно.

*-Компани нь 2019 оны 05-р сарын 22-ны өдөр “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д бүртгүүлэн компанийн нийт гаргасан хувьцааны 15%-ийг анхдагч зах зээл дээр нээлттэй арилжаалсан.

Компани нь 2019 оны 12-р сарын 31-нээр 103 ажилтан (2018: 57)-тай байсан.

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

2. Тайлан бэлтгэсэн үндэслэл

Тусдаа Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуйг Тэмдэглэл 37, Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй-д толилуулсан. Өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд уг бодлогуудыг толилуулж буй бүх тайлант үеүүдэд түүштай баримталж мөрдсөн болно.

Компанийн нягтлан бодох бүртгэлийн болон тайлагнагч валют нь Монгол улсын мөнгөн тэмдэгт болох Төгрөг юм. Эдгээр тусдаа санхүүгийн тайлангууд нь төгрөгөөр илэрхийлэгдэж, мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнагдсан.

Эдгээр тусдаа санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан НББОУС 27, *Тусдаа санхүүгийн тайлан* (“НББОУС 27”), болон тайлбарууд (хамтад нь ‘СТОУС’ гэх)-ын дагуу бэлтгэсэн.

Хавсаргасан санхүүгийн тайлан, түүний тодруулгууд нь НББОУС 27-ийн дагуу бэлтгэгдсэн компанийн тусдаа санхүүгийн тайлангуудыг илэрхийлэх бөгөөд компани нь охин болон хараат компаниудын санхүүгийн тайлангуудыг нэгтгэж, СТОУС-ын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэж толилуулсан.

Тусдаа Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд тодорхой, чухал нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийхийг шаарддаг. Мөн компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэхэд удирдлагаас шийдэл гаргахыг шаарддаг. Тусдаа санхүүгийн тайлан бэлтгэхэд хийгдсэн нөлөө бүхий шийдэл ба тооцоолол болон түүний нөлөөллийн талаар Тэмдэглэл 4, Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл-д нэмж тодруулсан.

Хэмжилтийн үндэслэл

Эдгээр тусдаа санхүүгийн тайлангууд нь доорх зүйлсээс (дэлгэрэнгүй мэдээллийг зохих нягтлан бодох бүртгэлийн бодлогоос харна уу) бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн:

- Санхүүгийн хэрэглүүр – бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх
- Санхүүгийн хэрэглүүр – бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх
- Болзошгүй төлбөр
- Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө
- Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө
- Дахин үнэлэгдсэн өмч, барилга, тоног төхөөрөмж
- Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр
- Мөнгөөр төлөгдөх, хувьцаанд суурилсан төлбөрийн өглөг.

3. Шинээр батлагдсан, нэмэлт өөрчлөлт оруулсан стандарт болон тайлбарууд

(а) 2019 оны 01-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөх шинэ стандартууд, түүний тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд

2019 оны 12-р сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланд мөрдөгдөх, Компанид нөлөө үзүүлэх дараах шинэ стандартууд нь Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт оруулсан:

- СТОУС 16 Түрээс (СТОУС 16); болон
- СТОУТХ 23 Орлогын татварын байр суурьтай холбоотой тодорхой бус байдал (СТОУТХ 23)

12-69 дүгээр хуудсан дахь тэмдэглэлүүд нь тусдаа эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“Инвекор ББСБ” ХК

**2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)**

3. Шинээр батлагдсан, нэмэлт өөрчлөлт оруулсан стандарт болон тайлбарууд (үргэлжлэл)

(а) 2019 оны 01-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөх шинэ стандартууд, түүний тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд (үргэлжлэл)

СТОУС	Шинэ тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд	Эхлэх огноо
СТОУС 16 2016 оны 01 дугаар сард гаргасан	СТОУС 16 нь НББОУС 17, Түрээс, СТСБХ 4, түрээс агуулсан хэлцэл эсэхийг тодорхойлох, ТБХ 15, Үйл ажиллагааны түрээс – Урамшуулал, ТБХ 27, Түрээсийн эрх зүйн хэлбэртэй холбоотой ажил гүйлгээний мөн чанарыг үнэлэх зэрэг стандарт, тайлбаруудыг орлоно. СТОУС 16-ын гол томоохон өөрчлөлт нь үйл ажиллагааны болон санхүүгийн түрээсийн хоорондын ялгааг арилгах мөн санхүүгийн байдлын тайланд хөрөнгийн "ашиглах эрхийг" болон түрээсийн гэрээний өр төлбөрийг тусгах цор ганц загварыг тодорхойлсон.	2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд заавал мөрдөнө.
СТОУТХ 23 2017 оны 06 дугаар сард гаргасан	СТОУТХ 23 нь орлогын татвартай холбоотой тодорхой бус байдал байгаа үед тайлант жилийн болон хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хэрхэн хэмжиж хүлээн зөвшөөрөхийг илүү тодорхой болгож өгсөн.	2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд мөрдөнө.

Эдгээр хоёр стандартын нөлөөний дэлгэрэнгүйг Тэмдэглэл 36, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө-д оруулсан. Дараагийн санхүүгийн жилд анх удаа мөрдөгдөж эхлэх НББОУС3-өөс гаргасан бусад шинэ болон нэмэлт өөрчлөлт оруулсан стандарт болон тайлбарууд нь Компанид нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна. Мөн түүнчлэн эдгээр нь Компанийн үйл ажиллагаа эсвэл Компанийн одоогийн нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцсэн нягтлан бодох бүртгэлийн хэрэгцээ шаардлагатай хамааралгүй болно.

(б) Хараахан мөрдөгдөж эхлээгүй байгаа шинэ стандартууд, түүний тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд

Компани хугацаанаас нь өмнө хэрэгжүүлэхээр шийдээгүй буюу ирээдүйн нягтлан бодох бүртгэлийн үеүдэд хэрэгжих НББОУС3-өөс батлан гаргасан хэд хэдэн стандартууд болон тайлбарууд байна. 2020 оны 01-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх гол нөлөө бүхий стандартууд нь:

- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга болон НББОУС 8 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт ба алдаа (Нэмэлт өөрчлөлт – Материаллаг байдлын тодорхойлолт)
- СТОУС 3 Бизнесийн нэгдэл (Нэмэлт өөрчлөлт – Бизнесийн тодорхойлолт)
- Шинэчлэгдсэн нягтлан бодох бүртгэлийн үзэл баримтлалын хүрээ

Компани нь эдгээр шинэ болон нэмэлт өөрчлөлт орсон стандартын нөлөөллийг үнэлэх ажлыг хийж байгаа болно.

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

3. Шинээр батлагдсан, нэмэлт өөрчлөлт оруулсан стандарт болон тайлбарууд (үргэлжлэл)

(б) Хараахан мөрдөгдөж эхлээгүй байгаа шинэ стандартууд, түүний тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд (үргэлжлэл)

Бусад

Компани Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс батлан гаргасан боловч хараахан мөрдөгдөж эхлээгүй байгаа дараах стандартууд нь компанид материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна. Үүнд:

- СТОУС 17 Даатгалын гэрээ (2021 оны 01-р сарын 01-нээс мөрдөнө) – 2019 оны 06-р сард Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс СТОУС 17-г 2022 оны 01-р сарын 01-нээс хүчин төгөлдөр мөрдөх нэмэлт өөрчлөлтийн төслийг гаргасан бөгөөд энэ нь одоогоор эцэслэн шийдэгдээгүй байна.

4. Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл

Компани нь ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой тодорхой тооцоолол ба төсөөлөл ашигладаг. Түүхэн туршлага болон үүссэн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл ажиллагааны тухай таамаглал гэх мэт бусад хүчин зүйлсэд үндэслэн тооцоолол ба шийдлийг тогтмол үнэлдэг. Ирээдүйд бодит үр дүн нь тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно. Дараагийн санхүүгийн жилүүдэд хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд материаллаг нөлөө үзүүлж болохуйц нөлөө бүхий эрсдэлтэй тооцоолол ба төсөөллийг доор дурдлаа.

Тооцоолол ба төсөөлөл

Тасралтгүй үйл ажиллагаа

Эдгээр тусдаа санхүүгийн тайлангуудыг тасралтгүйгээр үйл ажиллагаагаа явуулна гэсэн өөдрөг төсөөллийн үндсэн дээр бэлтгэсэн.

Бодит үнэ цэнийн хэмжилт

Компанийн санхүүгийн тайлан дахь хэд хэдэн хөрөнгө, өр төлбөр нь бодит үнэ цэнийн хэмжилт, тодруулгыг шаарддаг. Компанийн санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийн хэмжилтэд ажиглагдахуйц өгөгдлийг аль болох их хэмжээгээр хэрэглэдэг. Бодит үнэ цэнийн хэмжилтэд хэрэглэгддэг өгөгдлийг ажиглагдахуйц байдлаар нь гурван түвшинд ангилдаг ('бодит үнэ цэнийн шатлал'):

- Түвшин 1: Идэвхтэй зах зээл дэх ижил төстэй зүйлсийн жишиг үнэ (тохируулга хийгдээгүй)
- Түвшин 2: Түвшин 1-ээс бусад ажиглагдахуйц шууд эсвэл шууд бус өгөгдөл
- Түвшин 3: Үл ажиглагдахуйц өгөгдөл (зах зээлийн бус мэдээлэл).

Өгөгдсөн зүйлсийн бодит үнэ цэнийн хэмжилтэд томоохон нөлөө үзүүлэх хэрэглэсэн өгөгдлийн хамгийн бага түвшинд үндэслэн зүйлсийг дээрх түвшинд ангилдаг. Түвшин хооронд зүйлсийг шилжүүлэхдээ шилжүүлсэн үед нь хүлээн зөвшөөрнө.

Компани нь дараах зүйлсийг бодит үнэ цэнээр нь хэмждэг.

- Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө (Тэмдэглэл 21)
- Бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хэрэглүүр (Тэмдэглэл 5)
- Болзошгүй зүйлс (Тэмдэглэл 30)

Дээрх зүйлсийн бодит үнэ цэнийн хэмжилттэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг холбогдох тэмдэглэлүүдээс харна уу.

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

4. Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын тооцоолол

СТОУС 9-ийн дагуу санхүүгийн бүх хөрөнгийн ангиллын үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжихэд, ялангуяа үнэ цэнийн бууралтын алдагдлыг тодорхойлохдоо ирээдүйн мөнгөн гүйлгээний хэмжээ ба цаг хугаца, барьцаа хөрөнгийн үнэлгээ зэрэг тооцооллыг шаарддаг. Эдгээр тооцоолол нь нөөц өөр өөр хэмжээтэй болж өөрчлөхөд хүргэдэг хэд хэдэн хүчин зүйлээс хамаардаг.

Тооцоололд дараах үндсэн орц мэдээлэл, төлөөллүүд ашиглагддаг. Үүнд:

- Зээл эргэн төлөгдөхгүй байх магадлал /Exposure at default/ -PD
- Зээлийн эргэн төлөлт хийгдээгүйгээс хүлээх алдагдал /Loss given default/ - LGD
- Эдийн засаг ба/эсвэл зах зээлийн ерөнхий нөхцөл байдлын өөрчлөлт (ажилгүйдлийн түвшин, хүүгийн түвшин өсөх магадлал г.м.);
- Зээлдэгчийн үйл ажиллагааны үр дүн эсвэл санхүүгийн байдалд томоохон өөрчлөлт орох;
- Аж ахуйн нэгжийн авах боломжтой санхүүгийн дэмжлэгийн үнийн дүнд өөрчлөлт орох (толгой компаниас г.м.);
- Зээлийн гэрээний нөхцөлийг зөрчих боломж эсвэл таамаглал
- Төлбөр төлөлт хойшлогдох магадлал (Тэмдэглэл: зээлийн эрсдэлд томоохон өөрчлөлт ортол төлбөр хойшлогдох тохиолдол гарахгүй байж болно).

5. Санхүүгийн хэрэглүүр – Эрсдэлийн удирдлага

Компани нь үйл ажиллагаагаараа дамжуулж дараах эрсдэлүүдэд өртөж байдаг:

- a) Зээлийн эрсдэл
- b) Зах зээлийн эрсдэл
 - i) Хүүгийн түвшний эрсдэл,
 - ii) Гадаад валютын эрсдэл,
 - iii) Бусад зах зээлийн үнийн эрсдэл
- c) Төлбөрийн чадварын эрсдэл.

Бусад бүх бизнесийн нэгэн адил компани нь санхүүгийн хэрэглүүр хэрэглэснээс үүдэлтэй эрсдэлд өртдөг. Энэ тэмдэглэлд компанийн эрсдэлийн удирдлагын бодлого, энэхүү эрсдэлийг зохицуулах процесс ба түүнийг хэмжих аргуудыг тайлбарласан. Эдгээр эрсдэлтэй холбоотой нэмэлт тоон мэдээллүүдийг санхүүгийн тайланд зохих ёсоор толилуулсан.

Энэхүү тэмдэглэлд өөрөөр дурдаагүй л бол компанийн санхүүгийн хэрэглүүрийн эрсдэлд өртөмхий байдал, эдгээр эрсдэлийг зохицуулахад чиглэсэн зорилт, бодлого ба процесс болон түүнийг хэмжихэд хэрэглэгдсэн бодлогод өмнөх жилүүдтэй харьцуулахад ямар нэгэн биет өөрчлөлт ороогүй болно.

(i) Санхүүгийн үндсэн хэрэглүүрүүд

Санхүүгийн хэрэглүүрийн эрсдэл үүсгэдэг дараах үндсэн санхүүгийн хэрэглүүрүүдийг компани хэрэглэдэг:

- Зээл болон хүүгийн авлага
- Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө
- Хөрөнгө оруулалт
- Түрээсийн өр төлбөр
- Тогтмол хүүтэй зээл ба өр төлбөр
- Итгэлцлийн үйлчилгээний өр төлбөр

“Инвекор ББСБ” ХК

**2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)**

5. Санхүүгийн хэрэглүүр – Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

(ii) Санхүүгийн хэрэглүүрийн ангилал

2019 оны 12-р сарын 31-ний байдлаарх:

	Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт		Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх-Харилцагчдад олгосон цэвэр зээл		Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа санхүүгийн хөрөнгө		Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн өр төлбөр		Нийт дүн
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	
Санхүүгийн хөрөнгө									
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	-	4,440,168	-	-	-	-	-	-	4,440,168
Хөрөнгө оруулалт	3,989,710	-	-	-	-	-	-	-	3,989,710
Харилцагчдад олгосон зээл-цэвэр	-	61,943,821	1,662,559	(1,305,151)	-	-	-	-	62,301,229
Бусад хөрөнгө	-	2,227,609	-	-	1,055,576	-	-	-	3,283,185
	3,989,710	68,611,598	1,662,559	(1,305,151)	1,055,576	-	-	-	74,014,292
Санхүүгийн өр төлбөр									
Итгэлцлийн үйлчилгээний өр төлбөр	-	-	-	-	-	-	19,933,800	-	19,933,800
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	-	-	-	-	-	-	14,515,976	-	14,515,976
Бусад санхүүгийн өр төлбөр	-	-	-	-	-	-	4,186,441	-	4,186,441
	-	-	-	-	-	-	38,636,217	-	38,636,217

“Инвекор ББСБ” ХК

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

5. Санхүүгийн хэрэглүүр – Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

(ii) Санхүүгийн хэрэглүүрийн ангилал (үргэлжлэл)

2018 оны 12-р сарын 31-ний байдлаарх:

	Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт		Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх-Харилцагчдад олгосон цэвэр зээл		Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа санхүүгийн хөрөнгө		Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн өр төлбөр		Нийт дүн
	мян.төг	Үндсэн мян.төг	Хүү мян.төг	Эрсдэлийн сан мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	
Санхүүгийн хөрөнгө									
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	-	2,297,690	-	-	-	-	-	-	2,297,690
Хөрөнгө оруулалт	90	-	-	-	-	-	-	-	90
Харилцагчдад олгосон зээл-цэвэр	-	34,897,152	1,241,362	(1,270,228)	-	-	-	-	34,868,286
Бусад хөрөнгө	-	681,332	-	-	417,534	-	-	-	1,098,866
	90	37,876,174	1,241,362	(1,270,228)	417,534	-	-	-	38,264,932
Санхүүгийн өр төлбөр									
Итгэлцлийн үйлчилгээний өр төлбөр	-	-	-	-	-	-	10,374,109	-	10,374,109
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	-	-	-	-	-	-	13,867,446	-	13,867,446
Бусад санхүүгийн өр төлбөр	-	-	-	-	-	-	496,390	-	496,390
	-	-	-	-	-	-	24,737,945	-	24,737,945

“Инвекор ББСБ” ХК

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

5. Санхүүгийн хэрэглүүр – Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

(iii) Санхүүгийн хэрэглүүрээс олсон цэвэр олз/ (гарз)

2019 оны 12-р сарын 31

	Хүүгийн орлого	Хүүгийн зардал	Хураамжийн орлого/(зардал)	Бусад орлого/(зардал)	Эрсдэлийн зардал	Цэвэр олз/(гарз)
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	117,515	-	(4,190)	688,478	-	801,803
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх зээл болон зээллэг	19,242,252	-	666,504	(12,475)	(56,963)	19,839,318
Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа санхүүгийн хөрөнгө	-	-	-	(72)	(279,702)	(279,774)
Түрээсийн өр төлбөр	-	(120,739)	-	-	-	(120,739)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн өр төлбөр	-	(4,136,615)	-	(529,355)	-	(4,665,970)
Нийт	19,359,767	(4,257,354)	662,314	146,576	(336,665)	15,574,638

2018 оны 12-р сарын 31

	Хүүгийн орлого	Хүүгийн зардал	Хураамжийн орлого/(зардал)	Бусад орлого/(зардал)	Эрсдэлийн зардал	Цэвэр олз/(гарз)
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	12,912	-	(6,502)	611,466	-	617,876
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх зээл болон зээллэг	10,780,916	-	324,140	-	(880,264)	10,224,792
Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа санхүүгийн хөрөнгө	-	-	-	(4,092)	(91,503)	(95,595)
Түрээсийн өр төлбөр	-	-	-	(142,323)	-	(142,323)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн өр төлбөр	-	(2,572,561)	-	(533,539)	-	(3,106,100)
Нийт	10,793,828	(2,572,561)	317,638	(68,488)	(971,767)	7,498,650

“Инвекор ББСБ” ХК

**2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)**

5. Санхүүгийн хэрэглүүр – Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

(iv) Бодит үнэ цэнээр хэмжигдээгүй санхүүгийн хэрэглүүр

Бодит үнэ цэнээр хэмжигддэггүй санхүүгийн хэрэглүүрт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, худалдааны болон бусад авлага, харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа, худалдааны болон бусад өглөг болон зээлийн өглөг багтана.

2019 оны 12-р сарын 31-ний байдлаарх гол санхүүгийн хэрэглүүр болон Харилцагчдад олгосон цэвэр зээлийг шатлалаар харуулбал:

	2019 оны 12-р сарын 31-ээрх			
	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
<i>Зээлийн авлага-Бүтээгдэхүүнээр</i>				
Хэрэглээний	33,580,131	712,970	664,957	34,958,058
Барилга	10,141,144	189,318	65,865	10,396,327
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	5,943,303	20,450	32,072	5,995,825
Бөөний болон жижиглэн худалдаа	3,650,268	79,661	524,987	4,254,916
Үл хөдлөх хөрөнгийн	1,080,667	-	-	1,080,667
Бусад	4,668,223	287,284	302,520	5,258,027
Нийт зээлийн авлага	59,063,736	1,289,683	1,590,401	61,943,820
<i>Хүүгийн авлага-Бүтээгдэхүүнээр</i>				
Хэрэглээний	416,551	229,333	282,807	928,691
Барилга	59,362	32,682	40,302	132,346
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	18,839	10,372	12,791	42,002
Бөөний болон жижиглэн худалдаа	175,053	96,376	118,847	390,276
Үл хөдлөх хөрөнгийн	3,579	1,971	2,430	7,980
Бусад	72,333	39,822	49,108	161,263
Нийт хүүгийн авлага	745,717	410,556	506,285	1,662,558
<i>Үнэ цэнийн бууралт-Бүтээгдэхүүнээр</i>				
Хэрэглээний	(330,043)	(15,455)	(16,120)	(361,618)
Барилга	(299,305)	(6,032)	(3,371)	(308,708)
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	(37,109)	(289)	(407)	(37,805)
Бөөний болон жижиглэн худалдаа	(385,615)	(27,582)	(80,276)	(493,473)
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	-	-	-	-
Бусад	(96,916)	(3,169)	(3,460)	(103,545)
Нийт үнэ цэнийн бууралт	(1,148,988)	(52,527)	(103,634)	(1,305,149)
Харилцагчдад олгосон зээл-цэвэр	58,660,465	1,647,712	1,993,052	62,301,229

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

5. Санхүүгийн хэрэглүүр – Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

а) *Зээлийн эрсдэл*

Компанийн харилцагч ба хамтрагч тал нь гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргээ хугацаанд нь биелүүлээгүйн улмаас санхүүгийн алдагдал хүлээх эрсдэлийг зээлийн эрсдэл гэнэ. Компани нь харилцагчдад олгосон зээлийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтээ хангаж чадахгүй болох, барьцаа хөрөнгө үнэлгээгээ алдах, барьцаа хөрөнгөөр үүргээ гүйцэтгэж чадахгүй болох зэрэг эрсдэлд голчлон өртөж байна. Компани нь зээлийн эрсдэлийн удирдлагыг нэгдсэн байдлаар хэрэгжүүлж, Зээлийн хороогоор тогтмол хэлэлцэн шийдвэрлэх ба шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлдэг.

Компанийн зээлийн хорооноос гаргасан “Эрсдэлийн удирдлагын бодлого” журмыг зээлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг. Энэхүү журмаар эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг хоорондоо уялдаатай 5 үе шатаас бүрдэнэ гэж үзсэн.

1. Эрсдэлийг тодорхойлох
2. Эрсдэлийг шинжлэх, хэмжих
3. Эрсдэлийг үнэлэх- Эрсдэлийн онцлогт тохирсон тоо болон чанарын үнэлгээний аргачлал
4. Шийдвэрлэх
5. Дахин хянах

Зээлийн эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь зээлийн үйл ажиллагаанаас учрах эрсдэл болон хүлээгдэх өгөөжийг хамгийн оновчтой түвшинд байлгахад оршино.

ББСБ нь зээлийн эрсдэлийг удирдах үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримталдаг:

1. Хариуцлагатай байх
2. Хараат бус байх
3. Бодлого журмын хүрээнд үйл ажиллагаа явуулах
4. Зээлийн бүрдүүлбэрийг бүрэн хангах
5. Тогтмол байх
6. Тогтоосон хязгаарыг мөрдөж, зээлийг багцыг тараан байршуулах

Тус ББСБ нь нэг зээлдэгч буюу нэг бүлэг зээлдэгч болон нэг салбарт олгож болох зөвшөөрөгдсөн эрсдэлийн дүнгийн хязгаарыг тогтоох замаар зээлийн эрсдэлийн түвшнийг тодорхойлдог. Зээлийн эрсдэлд орж болох байдлаа ББСБ нь зээлдэгчид болон томоохон зээлдэгчийн хүүгийн төлбөр, зээлийн эргэн төлөлтийн хариуцлагаа биелүүлж чадах чадварын шинжилгээгээр удирддаг. Шаардлагатай үед зээлийн хязгаарыг өөрчилдөг. Зээлийн эрсдэлийг мөн барьцаа хөрөнгө болон байгууллага, хувь хүний гаргасан баталгаагаар удирддаг.

2018 болон 2019 онуудад ББСБ-ын хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, ажилтнууд тэдгээртэй холбогдох этгээд болон тэдний эзэмшлийн нэгжид олгох зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны дээд хэмжээ нь өөрийн хөрөнгийн 10 хувь, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 25 хувиас хэтрэхгүй гэсэн шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласан байна

“Инвескор ББСБ” ХК

**2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)**

5. Санхүүгийн хэрэглүүр – Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

а) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Холбоотой талд олгосон зээлийн дүн болон эзлэх хувиар харуулбал:

	2019 он		2018 он	
	мян.төг	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь	мян.төг	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь
Том зээлдэгчид олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив (40 том зээлдэгчээр)	19,188,970	47.32%	15,503,368	111.58%
Том зээлдэгчид олгосон зээл, зээлтэй адилтгах тооцох бусад актив (Хамгийн том зээлдэгч)	3,827,611	9.44%	2,489,544	17.92%
Хувь нийлүүлэгч, өөрийн ажилтан, холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив	3,025,796	7.46%	2,818,927	20.29%
Хувь нийлүүлэгч, өөрийн ажилтан, холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив (Хамгийн том зээлдэгч-1)	1,452,320	3.58%	1,388,520	9.99%

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө болон банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламжаас мөн зээлийн эрсдэл үүснэ. Банк санхүүгийн байгууллагуудын хувьд, хараат бусаар зэрэглэл тогтоогч байгууллагуудын хамгийн багадаа ‘Б’ үнэлгээтэй байхыг шаарддаг.

Банкны харилцах данс дахь мөнгө ба богино хугацаат хадгаламж

Компанийн харилцах болон хадгаламжийн дансууд нь дараах банк, санхүүгийн байгууллагуудад байршиж байна. (Стандарт энд Пүүрс болон Мүүдис агентлагийн рейтинг дээр үндэслэн нэгтгэн дор харууллаа):

	Мүүди Агентлаг Үнэлгээ	Стандарт энд Пүүрс Үнэлгээ	2019 оны 12 сарын 31 мян.төг	2018 оны 12 сарын 31 мян.төг
Банкны харилцах				
Худалдаа хөгжлийн банк	B3	B	730,603	1,878,748
Хаан банк	B3	-	1,303,967	202,717
			-	-
Банкны хадгаламж				
Худалдаа хөгжлийн банк		B	2,405,498	136,000
Нийт			4,440,068	2,217,465

“Инвескор ББСБ” ХК

**2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)**

5. Санхүүгийн хэрэглүүр – Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

a) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Зээлийн хязгаарын хэрэгжилтэд Зээлийн Хороо тогтмол хяналт тавьдаг. Тайлагналын өдрөөр удирдлага эдгээр санхүүгийн байгууллагууд өөрсдийн үүргээ биелүүлээгүйгээс алдагдал хүлээнэ гэж үзэхгүй байна. Үнэ цэнийн бууралтын шаардлагад нийцээгүй бүх санхүүгийн хөрөнгийн зээлийн алдагдалд өртөх хамгийн дээд хэмжээ нь дансны үнээр илэрхийлэгдэнэ.

b) Зах зээлийн эрсдэл

Хүүтэй, арилжаалагдах болон гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хэрэглүүр хэрэглэснээс үүдэлтэйгээр компани зах зээлийн эрсдэлд өртдөг. Энэ нь хүүгийн түвшин (хүүгийн түвшний эрсдэл), гадаад валютын ханш (гадаад валютын эрсдэл) эсвэл зах зээлийн бусад хүчин зүйлсэд (бусад үнийн эрсдэл) гарсан өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл юм.

i) Хүүгийн түвшний эрсдэл

Хүүгийн түвшний эрсдэл гэдэг нь зах зээл дэх зээлийн хүүгийн түвшний өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл юм.

Тайлант хугацааны эцсээрх санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрт хийх хүүгийн хувь хэмжээний мэдрэмжийн шинжилгээнд тулгуурлан хүүгийн хувь хэмжээний боломжит өөрчлөлт нь орлогын тайлан болон өөрийн хөрөнгөнд томоохон нөлөө үзүүлэхээргүй гэж тус ББСБ-ын удирдлага үзэж байгаа болно.

Компанийн хүүтэй зээл болон өр төлбөрийн үлдэгдэл болон хүүгийн түвшин нь дараах байдалтай байна:

	Хүүгийн түвшин /сараар/ %	2019 оны 12 сарын 31 мян.төг	Хүүгийн түвшин /сараар/ %	2018 оны 12 сарын 31 мян.төг
Хүү бүхий авлага				
Том зээл	-	-	1.20%	2,509,237
Байгууллагын бизнесийн зээл	1.5%-3.5%	13,186,260	1.7%-3.5%	5,129,702
Хувь хүнд олгосон бизнесийн зээл	1.5%-4.0%	10,964,690	1.6%-4.0%	10,002,991
Хэрэглээний зээл	1.6%-4.0%	11,588,815	1.6%-4.0%	1,844,554
Автомашин зээл	1.6%-3.9%	24,659,400	1.6%-3.7%	14,033,108
Кредит карт зээл	3.50%	459,258	3.50%	257,244
		60,858,423		33,776,836
Хүү бүхий өглөг				
Толгой компаниас авсан зээл	1.58%	9,574,323	1.58%	9,974,323
ХХБ-наас авсан зээл	1.9%-2.5%	959,258	1.9%-2.5%	1,757,244
Иргэнээс татсан итгэлцэл	2.7%-3%	11,843,127	7.5%-36%	6,623,510
Хүүлийн этгээдээс татсан итгэлцэл	2.7%-3%	7,138,018	8%-36%	3,224,477
		29,154,726		21,579,554

“Инвескор ББСБ” ХК

**2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)**

5. Санхүүгийн хэрэглүүр – Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

b) Зах зээлийн эрсдэл (үргэлжлэл)

ii) Гадаад валютын эрсдэл

Гадаад валютын эрсдэл гэдэг нь гадаад валютын ханшийн өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнэ хэлбэлзэх эрсдэл юм. Ирээдүйн ажил гүйлгээ, хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгө, өр төлбөр Монгол Төгрөгөөс өөр валютаар илэрхийлэгдсэн тохиолдолд гадаад валютын эрсдэл үүсдэг. Тэнцлийн болон тэнцлийн гадуурх гадаад актив, пассивын зөрүү нь нэгж болон нийт валютын хувьд өөрийн хөрөнгийн 40%-аас хэтрэхгүй байхыг СЗХ-оос шаарддаг.

Доорх хүснэгтэд 12-р сарын 31-ний байдлаарх гадаад валютын цэвэр эрсдэлийг харууллаа:

2019 оны 12-р сарын 31-нд	MNT	USD	JPY	Нийт
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Санхүүгийн хөрөнгө				
Мөнгө ба түүнтэй адилгах хөрөнгө	1,744,510	2,596,925	98,733	4,440,168
Хөрөнгө оруулалт	2,500,090	-	1,489,620	3,989,710
- (б) Түрээсийн эхлэл өдрөөс эхлэн СТОУС 16-г мөрдөж байсан мэтээр ашиглах эрхтэй хөрөнгийг тодорхойлсон түрээсийн анх мөрдөх өдрөөрх ашиглах эрхтэй хөрөнгийн хэмжилтээс анхны шууд зардлыг хасаж тооцох;
- (в) Анх мөрдөх өдрөөр НББОУС 36-гийн дагуу үнэ цэнийн бууралтын шалгалт хийлгүйгээр түрээс нь алдагдалтай эсэх тухай өмнөх үнэлгээг ашиглах; ба
- (г) Анх мөрдөх өдрөөр 12 сараас бага түрээсийн хугацаатай түрээснүүдэд ашиглах эрхтэй хөрөнгө ба өр төлбөр хүлээн зөвшөөрөхгүй байх чөлөөлөлтийг ашиглах.

“Инвекор ББСБ” ХК

**2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)**

36. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө (үргэлжлэл)

Компани нь түрээслэгч тал түл эзэмшлийг бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн эсэх тухай үнэлгээндээ үндэслэн түрээсийг үйл ажиллагааны эсвэл санхүүгийн түрээс гэж ангилдаг байсан. Компани нь СТОУС 16-гийн дагуу ихэнх түрээснүүддээ ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өр төлбөр хүлээн зөвшөөрдөг. Харин шинэ суурь хөрөнгийн үнэ цэнд суурилсан бага үнэтэй хөрөнгийн зарим түрээснүүд, эсвэл 12 сар эсвэл түүнээс бага хугацаатай богино хугацаат түрээснүүдэд ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өр төлбөр хүлээн зөвшөөрөхгүй байхаар сонгосон.

СТОУС 16-г мөрдөхдөө Компани дараах байдлаар ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн:

НББОУС 17-гийн дагуу хийсэн ангилал	Ашиглах эрхтэй хөрөнгө	Түрээсийн өр төлбөр
НББОУС 40-н дагуу хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тодорхойлолтыг хангасан үйл ажиллагааны түрээс (тэмдэглэл 16)	2019 оны 01-р сарын 01-ний өдрөөр бодит үнэ цэнээр	Үлдсэн түрээсийн төлбөрүүдийг 2019 оны 01-р сарын 01-ний өдрөөрх Компанийн зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшнийг ашиглан
Бусад бүх үйл ажиллагааны түрээс	<p>Оффисын талбай: Аливаа урьдчилгаа төлбөр эсвэл хуримтлагдсан түрээсийн төлбөрийн дүнгийн тохируулгыг хийсэн түрээсийн өр төлбөртэй тэнцэх дүнгээр ашиглах эрхтэй хөрөнгийг хэмжинэ.</p> <p>Бусад: Түрээсийн эхлэл өдрөөс эхлэн СТОУС 16-г мөрдсөн бол гарах байсан дансны үнэ цэнээр (дээр дурдсан практик чөлөөлөлтүүдийг мөрдөж болно.)</p>	дискаунтлан өнөөгийн үнэ цэнээр нь хэмжинэ. Компанийн зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшин гэдэг нь ижил хугацаа, нөхцөлтэйгөөр бие даасан зээлдүүлэгчээс ижил зээл авсан үед төлөх хүүгийн түвшин юм. Ашигласан жигнэсэн дундаж түвшин нь 18% байна.
Санхүүгийн түрээс	Анх мөрдөх өдрийн дөнгөж өмнөх түрээсийн хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнэд үндэслэн хэмжинэ (ж/нь: өмнөх үеэс тайланд үе рүү шилжсэн дансны үнэ, тохируулга хийгээгүй).	

“Инвескор ББСБ” ХК

**2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)**

36. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө (үргэлжлэл)

СТОУС 16-г мөрдсөнөөр 2019 оны 01-р сарын 01-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн байдлын тайланд үзүүлэх нөлөөг дараах хүснэгтээр харуулав:

	Тэм	Төв оффис мян.төг	Салбарууд мян.төг	Нийт мян.төг
Хөрөнгө				
Ашиглах эрхтэй хөрөнгө	(а)	623,316	187,577	810,893
Өр төлбөр				
Түрээсийн өр төлбөр	(б)	455,179	158,667	613,846
(а) Ашиглах эрхтэй хөрөнгөд хийсэн залруулга:				мян.төг
Үйл ажиллагааны түрээсээр бүртгэж байсан түрээс				613,846
				<u>197,047</u>
Ашиглах эрхтэй хөрөнгө				810,893

(б) Түрээсийн өр төлбөрт хийсэн залруулга:

Дараах хүснэгтэд Компанийн 2018 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланд тодруулсан түрээсийн хамгийн бага төлбөрийн үүргийг 2019 оны 01-р сарын 01-ний өдрөөр хүлээн зөвшөөрсөн түрээсийн өр төлбөрийн үнийн дүнтэй тохируулсан:

	2019 оны 1 сарын 1 мян.төг
2018 оны 12 сарын 31-ний өдрөөрх үйл ажиллагааны түрээсийн хамгийн бага төлбөрийн үүрэг	829,380
Хасах нь: СТОУС 16-гийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй богино хугацаат түрээс	-
Хасах нь: СТОУС 16-гийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй бага үнэ цэнэтэй түрээс	-
Нэмэх нь: түрээсийн гэрээг сунгах сонголтыг хэрэгжүүлэх нь үл үндэслэлтэйгээр тодорхой байгаа бол түүний нөлөө	-
Дискаунтчилаагүй түрээсийн төлбөрүүд	829,380
Хасах нь: анх мөрдсөн өдрөөрх зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшнийг ашиглах дискаунтчилсны нөлөө	215,434
НББОУС 17-гийн дагуу үйл ажиллагааны гэж ангилсан түрээснүүдийн түрээсийн өр төлбөр	613,846
Нэмэх нь: НББОУС 17-гийн дагуу өмнө нь санхүүгийн түрээс гэж хүлээн зөвшөөрсөн түрээснүүд	-
2019 оны 01 сарын 01-ний өдрөөрх түрээсийн өр төлбөр	613,846

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

36. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө (үргэлжлэл)

СТОУТХ 23 Орлогын Татварын Бүртгэлийн Тодорхойгүй Байдал

СТОУТХ 23 нь орлогын татварын байр суурьтай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдолд өнөөгийн болон хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийн бүртгэлийг хэрхэн хийх талаар заавраар хангана. Энэхүү Тайлбар нь дараах зүйлсийг шаарддаг:

- Компани нь тодорхой бус татварын байр суурийг тусд нь эсвэл нэгтгэж авч үзэх эсэхийг тодорхойлох;
- Тодорхой бус татварын байр суурийг татварын алба хүлээн зөвшөөрөх магадлалтай эсэхийг Компани тодорхойлох; ба
- Тодорхой бус татварын байр суурийг хүлээн зөвшөөрөх магадлалгүй бол тодорхой бус байдлын шийдвэрлэлтийг хамгийн сайн таамаглах аргаас хамаарч хамгийн боломжит үнийн дүн эсвэл таамагласан үнэ цэнийн аргад үндэслэн тодорхой бус татварын байр суурийг хэмжинэ. Энэхүү хэмжилтийг хийхийн тулд татварын алба тус бүр өөрсдийн шалгах эрхтэй бүхий л үнийн дүнг шалгах бөгөөд эдгээр шалгалтыг хийхдээ холбогдох бүх мэдээллийн талаар бүрэн мэдлэгтэй байна гэсэн төсөөлөлд суурилахыг шаарддаг.

Компани нь энэхүү стандартаар тайлагнагдах аливаа хуримтлагдсан нөлөө байхгүй бөгөөд ирээдүйд НББОУС 8 “ Нягтлан бодох бүртгэлийн бодлого, тооцооллын өөрчлөлт” өөр үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахаар нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт оруулсан.

37. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй

а. Орлого хүлээн зөвшөөрөлт

i) Хүү болон түүнтэй адилтгах орлого

Компанийн орлогын дийлэнх хэсэг нь харилцагчдад олгосон зээлийн хүүгийн орлогоос бүрддэг бөгөөд гэрээнд заасан эргэн төлөлтийн хувиарын дагуу тодорхой хугацааны турш орлого хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд аккруэл сууриар бүртгэж тайлагнадаг. Үр ашигт хүүгийн түвшин гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны турш хүлээн авах мөнгөн орлогын төлбөрийг санхүүгийн хөрөнгийн дансны цэвэр дүн хүртэл хөнгөлөх түвшин юм.

Компани нь төв салбартай нийлээд нийт 9 салбараар дамжуулан хүүгийн орлого олж байгаа. Харилцагчтай байгуулж буй зээлийн гэрээний дундаж хугацаа 24 сар бөгөөд зээлийн гэрээнд заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу системтэй төлөлт хийж байгаа тул тодорхой хугацааны турш орлого хүлээн зөвшөөрч бүртгэх гол үндэслэл болж байна.

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

37. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

а. Орлого хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)

i) Хүү болон түүнтэй адилтгах орлого

Компани нь харилцагчийн зээлийн хүүгийн түвшинг тодорхойлохдоо тухайлсан гэрээний нөхцөл болон өөрийн бизнесийн тогтсон практикийг харгалзан үздэг. Харилцагчтай байгуулсан гэрээнээс олох хүүгийн орлогын дүн нь зээлдэгчийн эргэн төлөлтөөс хамаарах хөнгөлөлттэй хүү болон үндсэн хүүгийн аль аль нь байж болдог.

Харилцагчидтай байгуулсан гэрээгээр зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу тодорхой хугацааны турш хүлээн зөвшөөрөгдөх хүүгийн орлогын дүн нь тодорхой заасан байдаг. Энэхүү эргэн төлөлтийн хувиар нь хөнгөлөлттэй хүүгийн түвшнийг ашиглан хийгддэг бөгөөд харилцагчийн эргэн төлөлтөөс хамааруулан үндсэн хүү болон нэмэгдүүлсэн хүүг тухай бүр тооцоолол хийн хүлээн зөвшөөрөх хүүгийн орлогын дүнг тодорхойлж тодорхой үеүдэд хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Компани нь үнэ цэнийн бууралтад орсон хөрөнгөөс бусад хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцдог. Энэ нь “Шатлал 1” болон “Шатлал 2”-д хамаарах санхүүгийн хөрөнгийн дансны үнээс гэрээнд заасан хүүгийн хувиар хүүгийн орлогыг аккруэл сууриар бүртгэл орлогын тайланд тусгадаг.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэн буурч “Шатлал 3”-д орсон тохиолдолд үр ашигт хүүгийн арга ашиглан санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан цэвэр өртгөөс хүүгийн орлогын тооцоолол хийдэг. Санхүүгийн хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орохоо больсон тохиолдолд хүүгийн орлогыг дансны үнээс тооцно.

ii) Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого

Компани нь өөрийн харилцагч нарт үзүүлсэн үйлчилгээнээс үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого олдог. Энэ нь ерөнхийдөө анх санхүүгийн хэрэглүүрийг гаргах үед аж ахуйн нэгжийн хүлээн авдаг үүсгэлтийн хураамж гэж ойлгож болно. Зээлийн хураамж шимтгэлийн орлого нь олгосон зээлийн дүнгээс хамаарч зээлийн гэрээ тус бүрд тусгагдсан байх бөгөөд зээл олгох үед зээлийн нийт дүнгээс гэрээнд заасан дүнгээр шимтгэл тооцож авдаг. Ийм хураамж нь зээлдэгчийн санхүүгийн нөхцөл байдлыг үнэлэх, баталгаа, барьцаа болон бусад аюулгүй байдлын арга хэмжээг үнэлэх ба бүртгэх, санхүүгийн хэрэглүүрийн нөхцөлийг хэлэлцэх тохиролцох, баримт бичгийг бэлтгэж боловсруулах, ажил гүйлгээг дуусгаж, хаах гэх мэт үйл ажиллагааны төлбөрийг багтаасан байж болдог. Энэхүү хураамж нь санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүгийн салшгүй нэг хэсэг болохгүй гэж үзэн хураамжийг СТОУС 15 “Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого” стандартын дагуу орлого хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

37. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

d. Санхүүгийн хөрөнгө

Хөрөнгө худалдан авсан зорилгоос хамаарч компани санхүүгийн хөрөнгийг доор дурдсан төрлүүдийн нэгээр нь ангилдаг. Хейджийн харьцааны шаардлага хангасан санхүүгийн хөрөнгөөс бусад санхүүгийн хөрөнгийг компани дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу ангилна:

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөд мөнгөөр төлөгдөх үүсмэл хэрэглүүр болон цаг хугацааны үнэ цэнийн нөлөөгөөр цэвэрлэгдэж сөрөг болсон мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүр багтана (өр төлбөрөөр ангилагдсан мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүрийн тухай “Санхүүгийн өр төлбөр” хэсгээс харна уу). Энэхүү ангилалд багтсан санхүүгийн хөрөнгийг тусдаа санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тусдаа ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн санхүүгийн орлого эсвэл зардлын мөрөнд тусгана.

Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх

Эдгээр хөрөнгө нь харилцагчид олгосон зээл болон түүний хүүгийн авлагаас ихэвчлэн. Гэхдээ мөн гэрээний мөнгөн үрсгалыг цуглуулах зорилгоор эзэмшиж байгаа бөгөөд гэрээний мөнгөн үрсгал нь зөвхөн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрөөс бүрддэг бусад төрлийн санхүүгийн хөрөнгөөс үүсдэг. Эдгээрийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнэ дээр тэдгээрийг олж авах эсвэл гаргахтай холбоотой шууд хамааралтай гарсан ажил гүйлгээний зардлыг нэмж бүртгэх ба дараа үед үр ашигт хүүгийн арга ашиглан тооцсон үнэ цэнийн бууралтыг хассан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Компани богино болон урт хугацаат зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг СТОУС 9-д заасан ерөнхий аргад үндэслэн нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тодорхойлох замаар хасагдуулгын матрицыг байгуулдаг. Ингэхдээ худалдааны авлагын төлөгдөхгүй байх магадлалыг үнэлдэг. Зээлийн авлагын нийт хугацааны туршид авлага төлөгдөхгүй байхаас үүсэх хүлээгдэж буй алдагдлыг тодорхойлж уг хүлээгдэж буй алдагдлыг энэхүү магадлалаар үржүүлж тооцно. Зээлийн авлагын хувьд уг хасагдуулгыг тусдаа нөөцийн дансанд бүртгэх ба цэвэр дүнгээр тайлагнана. Харин хүлээн зөвшөөрсөн алдагдлыг Тусдаа ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд зээлийн үнэ цэнийн бууралтын зардал болон буцаалт дансанд тусгана. Зээлийн авлагыг цуглуулж чадахгүй гэдгийг баталгаажуулснаар хөрөнгийн нийт дансны үнийг холбогдох нөөцтэй нь цэвэрлэж данснаас хасна.

Холбоотой талуудаас авах авлага болон холбоотой талуудад олгосон зээлд байгуулсан үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг хүлээгдэж буй зээлийн алдагдлын загвараар урьдчилан таамагласны үндсэн дээр тооцоолно. Хасагдуулгын дүнг тодорхойлохдоо ашигласан аргачлал нь санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт гарсан эсэхэд үндэслэнэ. Санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт гараагүй бол 12 сарын хүлээгдэж буй зээлийн алдагдлыг нийт хүүгийн орлоготой нь хамт хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт гарсан бол нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдлыг нийт хүүгийн орлоготой нь хамт хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Үнэ цэнийн бууралт үүссэн гэж тогтоогдвол нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүүгийн орлоготой нь хамт цэвэр сууриар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

37. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

d. Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

Компани нь зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдлыг ашиг, алдагдлын тайланд бүртгэх шаардлагатай эсэхийг үнэлэх үүднээс санхүүгийн байдлын тайлагналын хугацаа бүрд дангаараа томоохон дүнтэй зээл ба авлагуудыг хянаж үздэг. Бүх ангиллын хувьд үнэ цэнийн бууралтын алдагдлыг тодорхойлоход удирдлагын үнэлэмж орох бөгөөд ялангуяа ирээдүйн мөнгөн урсгалын дүн, хугацаа болон барьцаа хөрөнгийн дүнд орсон байдаг. Эдгээр тооцооллууд нь олон тооны хүчин зүйлүүдээр хөтлөгддөг бөгөөд тус хүчин зүйлүүдийг өөрчлөхөд өөр өөр түвшний сан үүсэх боломжтой. Мөн бүлгийн үнэлгээний өгөгдөл болон тохируулгын үнэлэмжид нэг төрлийн жижиг багцуудыг тодорхойлох, эрсдэлийн төвлөрлийн нөлөө болон эдийн засгийн мэдээлэл (үүнд эргэн төлөлтийн чиг хандлага, ипотекийн зээлийн үл хөдлөх хөрөнгийн үнийн индекс зэрэг барьцаа хөрөнгийн дүн, улсын эрсдэл, өөр өөр бүлгүүдийн гүйцэтгэл болон дампуурлын чиг хандлага) болон гэнэтийн нөхцөл байдлыг тодорхойлох зэрэг шалгуурууд багтдаг. Бодит алдагдлын нөхцөл байдал дээр тулгуурлан тооцоолох аргачлал болон таамаглалууд нь хянагдаж байдаг.

Үнэ цэнийн бууралтын тооцоолол:

Компани нь зээл ба урьдчилгааг СТОУС9-ийн дагуу ерөнхий арга ашиглан хүлээгдэж буй алдагдлын дүнг тодорхойлдог. Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх эсэх үнэлгээ нь тухайн тайлант үеийн эцсээр санхүүгийн хөрөнгийн зээлийн үнэлэмж буурч байгаа эсвэл, үл биелүүлэлт бодитоор гарч тохиолдсон талаарх нотолгоонд биш, харин анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш гэрээний үл биелүүлэлт гарч тохиолдох магадлал буюу эрсдэлийн мэдэгдэхүйц нэмэгдэлтэд үндэслэн тооцоолол хийдэг. Ингэхдээ нийт санхүүгийн хэрэглүүрийг 3 шатлалд хувааж авч үздэг.

Шатлал1- Анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн алдагдалд томоохон өсөлт гараагүй зээл болон түүнтэй адилтгах хөрөнгийг хамааруулдаг. Энэхүү ангилал дах санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед 12 сарын зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлаар сан бүртгэхээс гадна шатлал 2-оос эрсдэл нь буурч буй зээлүүд дахин ангилагдана.

Шатлал2- Анх хүлээн зөвшөөрснөөс зээлийн алдагдалд томоохон өсөлт гарсан зээл болон түүнтэй адилтгах хөрөнгийн хамааруулдаг. Энэхүү ангилал дах санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрснөөс хойших үүсэж болох эрсдэл ихэссэн үед нийт хугацааны зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлаар сан бүртгэхээс гадна шатлал 3-аас эрсдэл буурч буй зээлүүд дахин ангилагдана.

Шатлал3- Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан буюу алдагдал бий болсон зээл болон түүнтэй адилтгах хөрөнгийн хамааруулдаг. Энэхүү ангилал дах санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрснөөс хойших үүсэж болох эрсдэл ихэссэн үед нийт хугацааны зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлаар сан байгуулан бүртгэнэ.

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

37. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

d. Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

Компани нь дээрх гурван шатлалыг үр ашигт хүүгээр хорогдуулсан хүлээгдэж буй мөнгөн урсгалаар зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал (ЗҮЦХА)-г тооцоолдог. Мөнгөний урсгал нь гэрээний дагуух мөнгөн гүйлгээ болон эргэн төлөгдөхөөр хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний зөрүү юм. ЗҮЦХА тооцооллын гол нөлөөлөгч хүчин зүйлийг тайлбарлан харуулбал:

Зээл эргэн төлөгдөхгүй байх магадлал /Exposure at default/ -PD

Зээл төлөгдөхгүй байх эрсдэл тус бүрт үндэслэн тооцоолсон зээлийн алдагдлын жигнэсэн дунджыг илэрхийлнэ. Зээл эргэн төлөгдөхгүй байх магадлал нь үнэ цэнийн бууралтыг тооцох санхүүгийн хэрэгслийн нийт дансны үнийг илэрхийлж, зээлдэгчийн хувьд анхдагч болон боломжит эрт төлбөрт ойртох тусам өртөх чадвараа нэмэгдүүлдэг. Өөрөөр хэлбэл өгөгдсөн цаг хугацаанд төлбөрийн чадваргүй болох магадлалаар тооцоолно. Хэрвээ хэрэгсэл нь өмнө нь үл хүлээн зөвшөөрч байгаагүй мөн харгалзах багцад үргэлжлүүлэн байгаа бол үнэлсэн хугацааны тодорхой хугацаанд нэг удаа алдагдал үүсэх боломжтой

Зээлийн эргэн төлөлт хийгдээгүйгээс хүлээх алдагдал /Loss given default/ - LGD

Зээл нь тайлагналын дараах зээлийн хүлээгдэж буй өөрчлөлт, гэрээний дагуух үндсэн төлбөр болон хүүгийн эргэн төлөлт, зээлийн үүргийн хүрээнд нэмж олгосон дүн болон төлбөр хоцорсноор үүссэн хуримтлагдсан хүүг харгалзсан, ирээдүйн эргэн төлөлт хийгээгүйгээс хүлээх алдагдлыг тооцоолдог. Энэ нь гэрээний дагуу мөнгөн урсгал болон зээлдэгч хүлээн авахаар тооцоолсон дүн, барьцаа хөрөнгө борлуулсан дүнгийн нийлбэрийн зөрүүнээс тооцно.

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх

Компани нь охин компани, хараат компани эсвэл хамтын хяналттай аж ахуйн нэгжид багтаагүй, арилжаалах зорилгоор эзэмшдэггүй, хувьцаат болон хувьцаат бус аж ахуйн нэгж дэх стратегийн зорилго бүхий хөрөнгө оруулалт эзэмшиж байгаа тохиолдолд бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх хөрөнгө оруулалтаар ангилна. Эдгээрийг бодит үнэ цэнээр нь хэмжих бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Тусдаа ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч бүртгэх ба бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх нөөцөд хуримтлуулна. Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх нөөцийн үлдэгдлийг данснаас хасах замаар ашиг, алдагдал руу ангилахгүй ба харин шууд хуримтлагдсан ашиг руу ангилна.

Хөрөнгө оруулалтын өртгийн хэсгийг илэрхий нөхөх ногдол ашгаас бусад ногдол ашгийн хувьд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Харин уг тохиолдолд ногдол ашгийг бүхэлд нь эсвэл зарим хэсэг нь холбогдох хөрөнгө оруулалтын дансны үнээс хасаж бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгийн худалдан авалт болон борлуулалтыг бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх бодит үнэ цэнээр нь тохиролцоо хийсэн өдрөөр хэмжих ба арилжааны өдөр болон тохиролцоо хийсэн өдөр хоорондын бодит үнэ цэнийн аливаа өөрчлөлтийг бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх нөөцөд хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

37. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

е. Санхүүгийн өр төлбөр

Өр төлбөрийг олж авсан зорилгоос хамаарч компани санхүүгийн өр төлбөрийг доор дурдсан хоёр төрлийн аль нэгээр нь ангилдаг. Хейджийн харьцааны шаардлага хангасан санхүүгийн өр төлбөрөөс бусад санхүүгийн өр төлбөрийг компани дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу ангилна:

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт цаг хугацааны үнэ цэнийн нөлөөгөөр цэвэрлэгдэж сөрөг болоогүй мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүр багтана (цаг хугацааны үнэ цэнийн нөлөөгөөр цэвэрлэгдэж сөрөг болсон мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүр болон мөнгөөр төлөгдөх үүсмэл хэрэглүүрийн тухай “Санхүүгийн хөрөнгө” хэсгээс харна уу). Энэхүү ангилалд багтсан санхүүгийн өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Тусдаа ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана. Компани ашиг олох зорилгоор бус харин эрсдэлээс хамгаалах (хейдж) зорилгоор үүсмэл хэрэглүүр эзэмшиж, гаргадаг. Эдгээр үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусдаар компанид арилжаалагдах зорилготой эсвэл бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

Бусад санхүүгийн өр төлбөр

Бусад санхүүгийн өр төлбөрт дараах зүйлс багтана:

- Банкны зээл болон компанийн буцаан дуудах давуу эрхтэй хувьцааг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хэрэглүүрийг гаргахтай шууд холбоотой гүйлгээний зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр бүртгэнэ. Ийм төрлийн хүүтэй өр төлбөрийг дараа үеүдэд бүртгэхдээ үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцсон хорогдуулсан өртгөөр хэмждэг. Ингэснээр санхүүгийн байдлын тайлангаарх өр төлбөрийн үлдэгдэлд хүүгийн зардлыг эргэн төлөлтийн хугацааны турш тогтмол хувиар тооцоолох боломжийг олгодог. Санхүүгийн өр төлбөр бүрийн зорилгын хувьд хүүгийн зардалд анхны ажил гүйлгээний зардал, эргэлтээс гаргах өдөр төлөгдөх аливаа нэмүү өртөг болон төлөгдөөгүй өрийн хүү эсвэл купоны өглөг багтаадаг.
- Хөрвөгч зээлийн өрийн хэсгийг доор тайлбарласны дагуу хэмжинэ.
- Анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн худалдааны өглөг ба бусад богино хугацаат мөнгөөрх өр төлбөрийг дараа үеүдэд үр ашигт хүүгийн түвшин ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

г. Хувьцаат капитал

Компанийн гаргасан санхүүгийн хэрэгслүүд санхүүгийн өр төлбөр, хөрөнгийн шалгуурыг хангахгүй байх тохиолдолд л тэднийг өмчөөр ангилна. Компани энгийн хувьцаагаа өмчийн хэрэглүүр гэж ангилсан.

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

37. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

г. Ногдол ашиг

Ногдол ашиг нь хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан хөрөнгө оруулалтын өгөөжийн татан авалт юм. Ногдол ашиг олгох эсэх болон нэгж хувьцаанд хэдэн төгрөгийн ногдол ашиг олгохыг компанийн хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр тогтоох бөгөөд түүний зарласан тайлант хугацаанд нь өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.

h. Хөрвөх өр

Компани хөрвөгч өр гаргаснаас үүссэн олзыг түүний өр төлбөр, өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваарилдаг. Өрийн бүрэлдэхүүн хэсэгт анх хуваарилагдсан үнийн дүн нь ижил төрлийн хөрвөгч бус өрийн хэрэгсэлд төлөх байсан зах зээлийн хүүгийн түвшнийг хэрэглэн дискаунтчилсан мөнгөн гүйлгээтэй тэнцэнэ. Харин өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийг санхүүгийн өр төлбөр гэж үзэх бөгөөд бондын хугацаа дуусах өдөр эсвэл өрийг хөрвүүлэх хүртэл нь хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

i. Зээлийн өртөг

Хугацаа шаардсан хөрөнгийн худалдаж авах, барьж байгуулах, үйлдвэрлэхтэй шууд холбоотой зээлийн зардлыг тухайн хөрөнгө иж бүрэн, ашиглахад бэлэн болох хүртэлх хугацаанд капиталжуулдаг. Тухайн зорилгоор авсан зээлтэй холбоотой хүүгийн түвшин эсвэл компанийн зээлийн ерөнхий эх үүсвэр нь ашиглагдаж буй бол жигнэсэн дундаж хүүгийн түвшнээр санхүүгийн зардлыг капиталжуулдаг. Зээлийн өртгийн капиталжуулалт нь хөрөнгийн барьж босгох үйл явц зогссон үед дуусдаг. Бусад зээлийн өртөг нь тухайн зардал гарсан үеийн хугацаандаа санхүүгийн зардалд тайлагнагддаг.

j. Түрээс

Компанийн түрээстэй холбоотой ихэнх нягтлан бодох бүртгэлийн бодлогыг Тэмдэглэл 23 болон Тэмдэглэл 28 -д тайлбарласан.

Түрээсийг тодорхойлох

Гэрээ эсвэл гэрээний нэг хэсэг нь төлбөрийн хариуд хөрөнгийг ашиглах эрхийг тодорхой хугацааны турш олгодог бол түүнийг Компани түрээс гэж үздэг. Түрээс гэдэг нь дараах шалгууруудыг хангасан гэрээ юм:

- (a) Тодорхойлсон хөрөнгөтэй;
- (б) Хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн бараг бүх үр өгөөжийг Компани хүртдэг; ба
- (в) Компани хөрөнгийн ашиглалтыг удирдан чиглүүлэх эрхтэй.

Бэлтгэн нийлүүлэгч тухайн түрээсийн хөрөнгийг солих, орлуулах эрхтэй эсэхийг Компани харгалзан үзэх ба хэрэв тийм бол тухайн гэрээг түрээсийн гэрээ гэж үзэхгүй.

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

37. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

j. Түрээс (үргэлжлэл)

Бэлтгэн нийлүүлэгч тухайн түрээсийн хөрөнгийг солих, орлуулах эрхтэй эсэхийг Компани харгалзан үзэх ба хэрэв тийм бол тухайн гэрээг түрээсийн гэрээ гэж үзэхгүй.

Хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн бараг бүх үр өгөөжийг Компани хүртэх эрхтэй эсэхийг тодорхойлохдоо Компани нь хууль ёсны эзэмшил эсвэл бусад боломжит үр өгөөжтэй хамааралтай бус харин зөвхөн хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн үр өгөөжийг л авч үзнэ.

Компани нь хөрөнгийн ашиглалтыг удирдан чиглүүлэх эрхтэй эсэхийг тодорхойлохдоо ашиглалтын хугацааны туршид хөрөнгийг хэрхэн, ямар зорилгоор ашиглах, удирдан чиглүүлэх эрхтэй эсэхийг харгалзан үзнэ. Хөрөнгийн шинж чанарын үлмаас шийдвэр нь урьдчилан тодорхойлогдсон байх тул тухайн хөрөнгийг хэрхэн, ямар зорилгоор ашиглахтай холбоотой хамгийн их хамааралтай шийдвэр гаргахгүй байх үед Компани нь хөрөнгийн ашиглалтын загварыг гаргах үед ашиглалтын хугацааны турш хөрөнгийг хэрхэн, ямар зорилгоор ашиглахыг урьдчилан тодорхойлох байдлаар оролцсон эсэхийг харгалзан үзнэ. Хэрэв гэрээ эсвэл гэрээний нэг хэсэг нь эдгээр шалгуурыг хангахгүй бол Компани СТОУС 16-аас бусад холбогдох СТОУС-ын мөрдөнө.

к. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэдэг нь түрээслүүлэн орлого олох болон үнийг нь өсгөх зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгө бөгөөд бизнесийн үндсэн үйл ажиллагааны борлуулалт, бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ханган нийлүүлэлт болон захиргааны зориулалтгүй хөрөнгө болно.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө:

- хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн ирээдүйн өгөөжийг тухайн аж ахуйн нэгж хүртэх магадлалтай байвал;
- хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн өртгийг хэмжиж болохоор байвал өртгөөр нь үнэлнэ. Анхны хэмжилтэд худалдан авсан үнэ болон түүнд шууд хамаарах аливаа зарлагууд багтана.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дансны үнэнд хүлээн зөвшөөрөлтийн шалгуур хангаж буй бол тухайн хөрөнгөд нэмж төлсөн, аль нэг хэсгийг сольсон эсвэл үйлчилгээ хийхтэй холбоотой гарсан зардал багтаж болох бөгөөд ердийн үйлчилгээтэй холбоотой зардал нь багтахгүй.

Солигдсон эд ангийн дансны үнээр хөрөнгийн дансны үнийг бууруулаад, нэмж төлсөн дүнгээр хөрөнгийн дансны үнийг өсгөнө. Өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан тайлант үеийн тусдаа ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

Түрээсийн авлагыг шулуун шугамын арга хэрэглэн түрээсийн хугацаанд тэнцүү хуваарилна. Түрээслэгчид түрээсийн урамшуулал (түрээсээс чөлөөлөх гэх мэт) олгосон тохиолдолд түрээсийн орлогыг шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрсний үлмаас тусдаа хөрөнгө гэж тайлагнасан аливаа үнийн дүнг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнд багтаахгүй.

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

37. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

к. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (үргэлжлэл)

Хүлээн зөвшөөрөлтийн дараах хэмжилт

Компани бодит үнэ цэнийн загварын дагуу хөрөнгө оруулалтын зориулалттай бүх үл хөдлөх хөрөнгөө энэ загвараар хэмжиж бүртгэнэ. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөө бодит үнэ цэнийн загвараар бүртгэхдээ тайлант үе бүрийн эцэст хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг зах зээлийн нөхцөл байдлыг тусган өөрчилнө. Уг бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг тухайн тайлант үеийн Тусдаа ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг өртгийн загвараар бүртгэхдээ НББОУС 16, Өмч, барилга, тоног төхөөрөмж-ийн дагуу бүртгэнэ.

l. Худалдан авсан биет бус хөрөнгө

Гаднаас худалдан авсан биет бус хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрч дараа үеүдэд түүний өртгөөс хуримтлагдсан хорогдуулга ба үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр бүртгэж эдийн засгийн ашиглалтын хугацаанд нь шулуун шугамын аргаар хорогдуулна. Ашиглалтын хугацаа тодорхойгүй биет бус хөрөнгөд хорогдол тооцохгүй бөгөөд тайлант үе бүрийн эцэст аливаа үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг хянаж үзнэ.

Биет бус хөрөнгийг худалдан авсан аж ахуйн нэгжээс нь салгаж болохуйц эсвэл бусад гэрээгээр хүлээсэн үүргийг үүсгэж байгаа тохиолдолд бизнесийн нэгдлийн үед хүлээн зөвшөөрнө. Ийм төрлийн биет бус хөрөнгийн үнийн дүнг тохирох үнэлгээний арга техникийг ашиглан тооцоолно.

Компанийн хүлээн зөвшөөрсөн нөлөө бүхий биет бус хөрөнгө, тэдгээрийн эдийн засгийн ашиглалтын хугацааг доор харууллаа:

Биет бус хөрөнгө	Ашиглалтын хугацаа
Программ хангамж	10 жил

т. Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгө (хөгжүүлэлтийн зардал)

Дараах шалгууруудыг хангасан бол дотооддоо хөгжүүлсэн бүтээгдэхүүний зардлыг капиталжуулна:

- борлуулах бүтээгдэхүүнийг боловсруулах техникийн боломжтой
- хөгжүүлэлтийг гүйцэтгэх хэмжээний зохих нөөц бололцоотой
- бүтээгдэхүүнийг гүйцэтгэж, борлуулах зорилготой
- Компани бүтээгдэхүүнээ борлуулах чадвартай
- бүтээгдэхүүний борлуулалт нь ирээдүйн эдийн засгийн өгөөж бий болгох ба
- төслийн зарцуулалтыг найдвартай хэмжих боломжтой.

Боловсруулсан бүтээгдэхүүнийг борлуулснаар олохоор таамаглаж буй өгөөжийн хугацаанд капиталжуулсан хөгжүүлэлтийн зардлыг хорогдуулна.

“Инвекор ББСБ” ХК

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

37. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

п. Өмч, барилга, тоног төхөөрөмж

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрөх бөгөөд анхны өртөгт худалдан авсан үнэ, тухайн хөрөнгийг компанийн зориулалтын ажлын байршил, нөхцөлд бэлэн болгоход шаардагдах худалдан авалттай холбоотой зардлууд багтах бөгөөд үүнд мөн холбогдох зээлийн зардлыг оруулдаг.

Хүлээн зөвшөөрөлтийн дараах хэмжилт

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх хүлээн зөвшөөрсний дараа үеэс бодит үнэ цэнээс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр нь хэмжинэ. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн зүйлс нь ашиглалтын ялгаатай хугацаатай томоохон бүрэлдэхүүнээс бүрдэж буй тохиолдолд бүрэлдэхүүн хэсгүүдийг барилга, тоног төхөөрөмжийн тусдаа зүйл болгон бүртгэдэг.

Хүлээн зөвшөөрөлтийн дараах хэмжилт (үргэлжлэл)

Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг хангалттай давтамжтайгаар хийдэг бөгөөд ингэснээр дансны үнэ нь балансын өдрөөрх бодит үнэ цэнээс материаллаг байдлаар хэтрээгүй гэдгийг бататгадаг юм. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод тусгаж дахин үнэлгээний нөөцөд хуримтлуулна. Харин дахин үнэлгээний нөөцийн кредит үлдэгдлээс давсан үнэ цэнд бууралт үүссэн эсвэл ийм төрлийн ажил гүйлгээг буцаасан тохиолдолд ашиг, алдагдалд тусгадаг.

Элэгдэл

Газарт элэгдэл тооцдоггүй. Дүүсаагүй барилгыг бүрэн барьж, ашиглахад бэлэн болох хүртэл элэгдүүлдэггүй. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн бусад бүх зүйлсэд элэгдэл тооцох бөгөөд ингэснээрээ тэдний дансны үнэ цэнийг таамагласан ашиглалтын хугацааны туршид данснаас хасах юм. Тухайн хөрөнгийг зориулалтын ажлын байршил, нөхцөлд авчирсан буюу ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн элэгдүүлэх өртгөөс шулуун шугамын аргаар элэгдэл тооцох бөгөөд элэгдлийг тайлант жилийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Элэгдүүлэх өртөг нь тухайн хөрөнгийн анхны өртгөөс ашиглалтын хугацааны эцэст буцаан борлуулах боломжит өртгийг хассан дүн байна. Элэгдүүлэлтийн арга, ашиглах хугацаа, үлдэх өртгийг тайлагнах үе бүрд дахин тооцож үзнэ.

Өмч, барилга, тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна:

Өмч, барилга, тоног төхөөрөмж	Ашиглалтын хугацаа
Барилга	40 жил
Тоног төхөөрөмж	10 жил
Компьютер дагалдах хэрэгсэл	3 жил
Тээврийн хэрэгсэл	10 жил
Тавилга, эд хогшил	10 жил
Ашиглах эрхтэй хөрөнгө	Түрээсийн хугацаа болон ашиглалтын хугацааны аль багаар

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

37. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

о. Бараа материал

Бараа материалыг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрч дараа үеүүдэд өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь хэмжинэ. Бараа материалын өртөгт худалдан авалттай холбоотой бүх зардал, хувиргалтын зардал болон бараа материалыг өнөөгийн байршил ба нөхцөлд авч ирэхтэй холбоотой гарсан бусад бүх зардал багтана.

Цэвэр боломжит үнэ цэнэ нь тогтоогдсон борлуулах үнээс зарж борлуулахтай холбоотой зардлуудыг хассан дүнгээр тодорхойлогдоно. Хуучирсан, илүүдэл нөөцтэй, болон удаан гүйлгээтэй бараа материалуудыг олж тогтоож, цэвэр боломжит үнэ хүртэл нь бууруулж бүртгэдэг.

Хэвийн харилцан сольж болохуйц зүйлсийн өртгийг тодорхойлоход жигнэсэн дундаж өртгийг хэрэглэдэг.

р. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба бүлэг хөрөнгө

Дараах тохиолдолд эргэлтийн бус хөрөнгө болон борлуулах бүлэг хөрөнгийг борлуулах зорилготой гэж ангилна:

- Шууд борлуулахад бэлэн
- Удирдлага бүтээгдэхүүнийг борлуулахаар шийдсэн
- Төлөвлөгөөнд ямар нэгэн томоохон өөрчлөлт орох эсвэл төлөвлөгөөг цуцлах магадлал бага
- Худалдан авагчдыг тогтоох идэвхтэй хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн
- Хөрөнгө эсвэл борлуулах бүлэг хөрөнгийг бодит үнэ цэнтэй нь харьцуулахад тогтоосон үнэ нь үл үндэслэлтэй, ба
- Ангилал хийсэн өдрөөс хойш 12 сарын дотор борлуулалт хийгдэнэ гэж үзэж байгаа.

Борлуулах зориулалттай гэж ангилсан эргэлтийн бус хөрөнгө болон борлуулах бүлэг хөрөнгийг дараах зүйлсийн аль багаар нь хэмжинэ:

- Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу борлуулахад бэлэн гэж ангилахын өмнөх дансны үнэ; ба
- Борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнэ.

Борлуулах зорилготой гэж ангилсны дараа эргэлтийн бус хөрөнгийг (борлуулах бүлэг хөрөнгө дэх хөрөнгө багтана) элэгдүүлэхгүй.

Тайлант жилд борлуулсан үйл ажиллагааны үр дүнг Тусдаа ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд борлуулалтын өдөр тусгана.

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

37. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

а. Санхүүгийн орлого/зардал

Санхүүгийн орлого, зардалд хүүгийн орлого/зардал, гадаад валютын ханшийн зөрүүгийн олз/гарз, санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийн олз/гарз, ажилчдын тэтгэмжийн төлөвлөгөөний олз/гарз хамаарна. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн орлого олсон тайлант үеийнх нь Тусдаа ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

Капиталжуулах шаардлагыг хангасан хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай капиталжуулагдсан зээлийн өртгөөс бусад бүх зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн гарсан тайлант үеийнх нь Тусдаа ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

г. Тайлант жилийн болон хойшлогдсон татвар

Татварын зардал нь тайлант жилийн болон хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэх бөгөөд Тусдаа ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагддаг. Компанийн татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох балансын өдрөөр хүчинтэй байгаа татварын хувь хэмжээгээр тооцсон бөгөөд өмнөх үеийн татварын өглөг, хойшлуулсан татвар хөрөнгө ба өр төлбөрийг тохируулсан хүлээгдэж буй татварын хөрөнгө эсвэл өглөг юм.

Санхүүгийн байдлын тайланд тусгасан хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ нь татварын сууриас зөрүүтэй байгаа тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр хүлээн зөвшөөрдөг. Харин дараах зүйлсээс үүссэн зөрүүг хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр гэж үзэхгүй:

- Гүүдвилийн анхны хүлээн зөвшөөрөлт
- Тухайн ажил гүйлгээ гарсан үедээ нягтлан бодох бүртгэлийн эсвэл татварын ашгийн алинд нь ч нөлөөлдөггүй, бизнесийн нэгдлийн бус ажил гүйлгээний хөрөнгө, өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлт, ба
- Гарсан зөрүүнд буцаалт хийх хугацааг компани хянах чадвартай охин компани болон хамтарсан хэлэлцээрт оруулсан хөрөнгө оруулалт ба тухайн зөрүүг ойрын ирээдүйд буцаахгүй байх магадлалтай байх.

Ирээдүйн татвар ногдуулах ашиг нь татварын түр зөрүүг нөхөхүйц байх тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үе бүрд хянаж холбогдох татварын өгөөжийг хэрэгжүүлэх буюу бууруулдаг.

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

37. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

г. Тайлант жилийн болон хойшлогдсон татвар (үргэлжлэл)

Хойшлогдсон татварыг тайлагнах өдрөөрх болон цаашид хэрэгжих хуульд үндэслэн буцаалт хийгдэх түр зөрүүнд хэрэгжихээр хүлээгдэж байгаа татварын хувиар тооцдог.

Хөрөнгө эсвэл өр төлбөрийн татварын суурь, тодорхой ажил гүйлгээний татвар ногдох байдал, эсвэл татвартай холбоотой бусад төсөөлөлтэй холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдолд [Компани/Групп] нь:

- Тодорхой бус татварын байр суурийг тусад нь эсвэл багцлан авч үзэх эсэх (шийдвэрлэлтийг нь хамгийн сайн таамаглаж чадах аргад үндэслэнэ);
- Тодорхой бус татварын байр суурийг татварын алба хүлээн зөвшөөрөх магадлалтын эсэхийг тодорхойлох: ба
- Тодорхой бус татварын байр суурийг хүлээн зөвшөөрөх магадлалгүй бол тодорхой бус байдлын шийдвэрлэлтийг хамгийн сайн таамаглах аргаас хамаарч хамгийн боломжит үнийн дүн эсвэл таамагласан үнэ цэнийн аргад үндэслэн тодорхой бус татварын байр суурийг хэмжинэ. Энэхүү хэмжилтийг хийхийн тулд татварын алба тус бүр өөрсдийн шалгах эрхтэй бүхий л үнийн дүнг шалгах бөгөөд эдгээр шалгалтыг хийхдээ холбогдох бүх мэдээллийн талаар бүрэн мэдлэгтэй байна гэсэн төсөөлөлд суурилахыг шаарддаг.

Компани нь тайлант жилийн татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэрлэх хуульд заасан эрхтэй бөгөөд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь нэг ижил татварын эрх бүхий байгууллагад ногдуулсан татвартай дараах нөхцөлийн аль нэг байдлаар холбоотой байгаа бол хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг хооронд нь цэвэрлэнэ.

- Татвар ногдуулах ижил байгууллага, эсвэл
- Татвар ногдуулах ялгаатай байгууллагаас цэвэр сууриар тайлант үеийн өр төлбөрийг ба хөрөнгийг барагдуулах эсвэл ирээдүйн тайлант үе бүрд барагдуулахаар буюу нөхөхөөр төлөвлөсөн хойшлогдсон татварын өр төлбөр буюу хөрөнгийн нөлөө бүхий дүнгээр хөрөнгийг хүлээн авсан ба өр төлбөрийг нэгэн зэрэг барагдуулахаар төлөвлөсөн.

s. Нэгж хувьцаанд ногдох ашиг/(алдагдал)

Нэгж хувьцаанд ногдох ашиг(алдагдал) нь компанийн тайлант жилийн түрш эргэлтэд байсан энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд хуваарилагдсан цэвэр ашиг, алдагдлаар тооцоологддог. Энэ нь энгийн хувьцаа нэг бүрд ногдох тайлант жилийн ашиг, алдагдлын дүнг илэрхийлнэ. Компани аливаа хорогдуулагч хэрэглүүр эзэмшдэг бол нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг(алдагдал)-ийн тооцоог мөн хийж тайлагнана.

t. Ажилчдын тэтгэмж

Түр хугацааны ажилчдын тэтгэмж

Богино хугацаат ажилчдын тэтгэмж нь хөнгөлөлтгүй сууриар хэмжигддэг бөгөөд ажилчдын ажил гүйцэтгэсэн тайлант үед нь зардлаар бүртгэдэг. Хэрэв ажилчдын гүйцэтгэсэн ажлын үр дүнгээс үүдэн компани хуулийн дагуу бонус өгөх хариуцлага хүлээх болон бонусын дүнг үндэслэлтэй тооцоолох боломжтой үед тооцоолсон дүнгээр богино хугацаат бонусын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

37. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

и. Ажилчдын тэтгэмж (үргэлжлэл)

Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал

Монгол улсын хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниуд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухайн үед нь ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

и. Холбоотой талууд

Хэрвээ тухайн компани нь нөгөө этгээдийн санхүүгийн болон үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтад шууд ба шууд бусаар нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол тухайн этгээд нь тухайн компанийн хувьд холбоотой тал болох ба хэрвээ тухайн компани өөр этгээдийн удирдлага хяналт дор байдаг эсвэл дээр дурдсан харьцаа нь эсрэгээрээ байх тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэх зорилгоор холбоотой талууд гэж тодорхойлдог. Холбоотой талууд нь хувь хүмүүс болон бусад аж ахуйн нэгжүүд байж болно.

а) Аливаа хувь хүн эсвэл түүний ойр дотнын гэр бүлийн гишүүнийг дараах тохиолдлуудад компанийн хувьд холбоотой тал гэж үзнэ. Хувь хүн нь:

- (i) Компанийг хянадаг эсвэл хамтын хяналттай бол;
- (ii) Компанид мэдэгдэхүйц нөлөөтэй бол; эсвэл
- (iii) Компани эсвэл түүний толгой компанийн гол удирдлагын багийн гишүүний нэг бол.

Компанийг дараах тохиолдлуудад нөгөө компанийн холбоотой тал гэж үзнэ:

- (i) Нэг групп компанийн бүрэлдэхүүн компаниуд хоорондоо холбоотой талууд байна;
- (ii) Компани нь нөгөө компанийнхаа хараат компани эсвэл хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол (эсвэл компани нь нөгөө компанийн харьяалагддаг группийн өөр нэг гишүүн компанийн хараат компани эсвэл хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол);
- (iii) Хоёр компани хоёулаа нэг ижил гуравдагч талын хамтарсан хөрөнгө оруулалттай компаниуд бол;
- (iv) Компани нь гуравдагч талын хамтарсан хөрөнгө оруулалттай компани ба нөгөө компани нь уг гуравдагч талын хараат компани бол;
- (v) Компани нь нөгөө компанийн эсвэл түүнтэй холбоотой компанийн ажиллагсдын ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөрийн үйл ажиллагааг эрхэлдэг бол;
- (vi) (a)-д тодорхойлогдсон хувь хүн нөгөө компанид хяналт эсвэл хамтын хяналттай бол; эсвэл
- (vii) (a)(i)-д тодорхойлогдсон хувь хүн нөгөө компанид мэдэгдэхүйц нөлөөтэй, эсвэл нөгөө компани эсвэл түүний толгой компанийн гол албан тушаалтны нэг бол.

Компанитай хийх хэлцэлд өөрөө болон уг хувь хүнээр дамжуулан нөлөө үзүүлэх магадлалтай гэр бүлийн гишүүдийг ойр дотнын гэр бүлийн гишүүнд тооцно.

Холбоотой талуудын хооронд ажил гүйлгээ гарсан эсэхээс үл хамааран тэдгээрийн хоорондын харилцааг тодруулах ёстой.

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэл (үргэлжлэл)

37. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Холбоотой талуудын ажил гүйлгээний тодруулгад дараах зүйлсийг тодруулна.

- (а) Худалдан авалт
- (б) Борлуулалт
- (в) Түрээс
- (г) Зээл
- (д) Аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс эсвэл холбоотой талын нэрийн өмнөөс аж ахуйн нэгж өр төлбөрийг барагдуулах

Компанийн санхүүгийн тайланд холбоотой талуудын ажил гүйлгээний нөлөөллийг тусад нь харуулах шаардлагатайгаас бусад тохиолдолд ижил үзүүлэлтүүдийг нийтэд нь тодруулж болно.

38. Тайлант хугацааны дараах үйл явдал

Дараах ажил гүйлгээнүүд болон үйл явдал нь тайлант жилийн эцсийн өдөр болон санхүүгийн тайланг хэвлэн нийтлэх зөвшөөрөл олгогдсон өдрийн хооронд гарсан.

2020 оны 02-р сарын 13 өдрийн ТУЗ-ын № А/06-Т тогтоолоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах асуудлыг хэлэлцсэн. Энэхүү хурлын тогтоолоос Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн Биржийн холбогдох журмын дагуу олон нийтэд нээлттэй арилжаалах зорилгоор нийт 5 000 000 000 (таван тэр бум) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (Баталгаат үнэт цаас)-ыг 2020 оны эхний хагаст багтаан гаргахаар шийдвэрлэсэн.

Коронавирусын халдвар (COVID 19) нь дэлхийн нийтээр 194 улс, бүс нутагт бүртгэгдэн улс орнуудын хүн амын эрүүл мэндээс гадна эдийн засагт томоохон цохилт болж байна. Энэхүү нөхцөл байдалтай уялдуулан 2020 оны 03-р сарын 17-ны өдрийн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хуралдаанаар санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, харилцагч, зээлдэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 144/125, 145/124 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Банк санхүүгийн байгууллагын активыг ангилал, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”- н шийдвэрт 2020 оны 01-р сарын 31-ний өдрөөс 2020 оны 07-р сарын 31-ний өдрийг хүртэл дараах шийдвэрүүдийг түр хугацаанд мөрдөн ажиллахаар болсон:

1. Зээлийн гэрээний хугацааг 2 болон түүнээс дээш удаа сунгасан бол зээлдэгчийн зээлийн ангилал өөрчлөгдөж хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлд шилжиж “Зээлийн мэдээллийн сан”-д бүртгэгдэж байсныг зохицуулалтын үйлчлэлийг дээрх хугацаанд зогсоох;
2. Зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн эргэн төлөлт нь хугацаандаа хийгдэж байгаа бол хэвийн зээлд тооцохоор байсныг 120 хоногоор хугацаа хэтэрсэн бол хэвийн зээлд тооцохоор, хугацаа хэтэрсэн зээлийн ангилалд 1-90 хүртэл хоног байсныг 121-180 хоног, чанаргүй зээлийн ангилалд 181 хоногоос дээш хугацаанд хугацаа хэтэрсэн тохиолдолд бүртгэж байхаар тус тус зохицуулалт хийсэн.

39. Тайлангийн орчуулга

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Монгол, Англи хэл дээр бэлтгэсэн бөгөөд тэдгээрийн хооронд ялгаа, зөрчилдөх зүйл гарвал Монгол хэл дээрх хувийг баримтална.